

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл


2013. 04 сар. №07 (041)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

Эдийн засаг эмтрэн унаж байна

Бидний алдааг битгий давтаарай

## УУЛ УУРХАЙН ИЛЧ БУУРАВ УУ





# consult expo 2013

- Менежмент, стратеги,
- Маркетинг, хүний нөөц,
- Компанийн засаглал,
- Санхүү, хөрөнгө оруулалт, аудит,
- Програм хангамж,
- Инженеринг, барилга, уул уурхай
- Байгаль орчин зэрэг мэргэжлийн чиглэлийн зөвлөхүүд оролцоно

**БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ  
УРЬЖ БАЙНА**

**ҮЗЭСГЭЛЭН:**

Зөвлөх үйлчилгээний 50 гаруй байгууллагуудыг нэгтгэсэн үзэсгэлэн Монголд анх удаа

**IV/5-6-ны өдрүүдэд  
БЛЮ СКАЙ ТАУР**

1-р давхарын үзэсгэлэнгийн танхимд

**ФОРУМ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:**

Зөвлөхүүдэд зориулсан  
**IV/05-нд 14:00-17:00**

Бизнес эрхлэгчдэд зориулсан  
**IV/06-нд 10:00-16:00**



RIVER GARDEN хотхон нь унаган байгаль болон уран сэтгэмжээр бүтээсэн ногоон төгөл дунд сүндэрлэн босох аз жаргалын өргөө юм. Хотхоны нийт талбайн 80%-иас багагүй хувьд төрөл бүрийн мод, бут, сөөг, зүлгийн гайхалтай хослол бүхий ногоон байгууламж, усан оргилуур, амрах талбай, тоглоомын талбай, усан сан зэрэг тав тухтай орчныг бүрдүүлсэн болно.



**PENTHOUSE APARTMENT**  
161.4m<sup>2</sup> - 395.5m<sup>2</sup>  
117m<sup>2</sup> - 282m<sup>2</sup>

**УДАХҮЙ АШИГЛАЛТАНД ОРОХ APARTMENT**  
199m<sup>2</sup> - 282m<sup>2</sup>  
**ЦӨВН ҮЛДЛЭЭ...**

# BEST LOCATION



RIVER GARDEN хотхон Улаанбаатар хотын хамгийн үнэ цэнэтэй бүс болох Богд Хан уулын бэл, Хатан Туул голын хөвөөнд үзэсгэлэнт байгаль, цэвэр агаарт эрхэм таны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Хүүхдийн парк, Skyresort цанын бааз, Зайсан толгой, Их тэнгэрийн ам, Голфийн талбай зэрэг газруудтай ойрхонбайрладаг. Хотын төв цэгээс ердөө 3 километрийн зайд авто зам, дэд бүтцийн таатай бүсэд байрладаг.

Захиалга авах хаяг:  
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо Их Монгол Улсын гудамж  
Маршалын гүүрнээс баруун тийш 150м RIVERGARDEN хотхон  
**ЗАГВАРЫН БАЙР**

[www.rivergarden.mn](http://www.rivergarden.mn)

Даваа - Баасан **09<sup>00</sup> - 18<sup>00</sup>**  
Бямба - Ням **11<sup>00</sup> - 17<sup>00</sup>**

Утас: 9901-3893 9903-3893 English Russian  
9910-3893 9905-3893 English  
9999-3893 9907-3893 Korean

Ногоон хөгжлийн шөлөө

# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Х.Хулан

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Б.Лхагвачулуун

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав /8880-0825/

Д.Баттулга /9902-2279/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш /8870-3633/

**“ECONOMY” ТВ СТУДИ**

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

[info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

**БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:**

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж глаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

MONGOLIAN ECONOMY  
SUBSCRIBE ONLINE

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

## Эдийн засаг эмтрэн унаж байна



...Шинжээчид Монголыг Голланд өвчний хүнд хэлбэрт орсныг тодорхой бодлогогүй, зөв чиглэлгүй, олон эзэнтэйн балаг хэмээн тодорхойлж байна...

9

## Тавантолгойд гарц хайсаар

...“Эрдэнэс Тавантолгой” компани хэцүүхэн байдалтай тэсэж байна. Тэд Засгийн газрыг царайчилж, хөрөнгө оруулагчдад найдлага тавьсан харц чулуудсаар...

20

## Хөгжилд хүргэх шинэ зам

...Төмөр зам дагасан бүтээн байгуулалт бий болгоход төрөөс ихээхэн хөрөнгө, холч ухаан, оновчтой бодлого хэрэгтэй нь дамжиггүй...

22

## “Хүнд итгэл хүлээлгэж, сэтгэлтэй болгох маш чухал”

...Шагдарсүрэн захирлыг гэр бүлийн бизнесээ эхлүүлж байх үед ном эрдмийн мөр хөөх насанд явсан Ш.Уламбаяр, Ш.Баярсайхан, Ш.Энхбаяр гэсэн гурван хүү нь өнөөдөр Монголын худалдаа, үйлдвэрлэл, барилгын салбарт тод мөрөө гаргасан шинэ үеийн томоохон бизнесмэнүүдийн төлөөлөл болж чаджээ...



40

## УУЛ УУРХАЙ

- 8 Уул уурхайн илч буурав уу
- 9 Эдийн засаг эмтрэн унаж байна
- 16 Тооны хэлээр
- 18 “Mongolian Economy” сэтгүүлийн асуулт
- 20 Тавантолгойд гарц хайсаар
- 22 Хөгжилд хүргэх шинэ зам
- 24 “Голланд өвчин”-ийг анагаагч
- 28 Бидний алдааг битгий давтаарай

## ЭДИЙН ЗАСАГ

- 32 Хөгжлийн шийдэл хаанаас эхлэх вэ
- 34 Итгэл бас өөдрөг хүлээлт

## ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 36 Улсын мөхөл
- 38 Шинэ Герман болох хараахан болоогүй

## БИЗНЕС

- 40 “Хүнд итгэл хүлээлгэж, сэтгэлтэй болгох маш чухал”

МОНГОЛД

**ЭРЧИМ ХҮЧ**

Японы “Хитачи” компани манай Эрчим хүчний яамтай хамтран эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан станц барихаар болжээ. Японы Хөдөө аж ахуйн яамны дэд сайд болон Эрчим хүчний яамны дэд сайд Д.Доржпүрэв нар барилгын ажлын төлөвлөгөөтэй өнгөрсөн сард танилцсан байна.

**БАНК, САНХҮҮ**

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос МҮХАҮТ-д Санхүүгийн салбарын шинэчлэлийн бодлого ба банкны зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулах бодлого боловсруулах үүрэг өгсөн. Ажлын хэсгийнхэн зээлийн хүү буурахгүй байгаа шалтгаан эдийн засгийн чухал салбаруудад төрийн оролцоо их буюу зах зээл өөрөө хөгжих боломж тааруу байгаагтай холбон тайлбарлажээ.

**УУЛ УУРХАЙ**

Монгол Улсын нүүрсний салбарын зах зээлийн тойм судалгаанд “Хятадын гадаад зах зээлээс импортлох нүүрсний хэмжээ ирэх 2015 онд 230 сая тонн-д хүрнэ. Үүнээс 58 сая тонн нь коксжих нүүрс байна” гэж онцолжээ. Эрдэс баялгийн эдийн засагч, судлаач Т.Баасанпүрэв “Монголын нүүрсний салбар экспортын зах зээл дотооддоо өрсөлдөөнтэй байх ч төмөр зам болон хил, гаалийн хүчин чадлаа өсгөснөөр Хятадын нүүрсний зах зээлд хүч түрэн орж ирэх боломж нээлттэй байна” гэв.

**Эдийн засгийг** төрөлжүүлэх салбарт Засгийн газрын оролцоо их байгааг хөндлөнгийн судлаачид шүүмжилж байна. Дэлхийн банкны гаргасан судалгаагаар жил ирэх бүр Засгийн газрын зарлага өсч байгаа нь төрөөс ач холбогдол, дэс дараалалгүй хөрөнгө оруулалт хэт их хийж байгаагтай холбоотой гэжээ.

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ**

ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулдаг гэж үздэг. Харин хөгжүүлэхийн тулд ЖДҮ-ийн зардлыг бууруулж, үйл ажиллагаагаа өргөтгөх, технологийн шинэчлэл хийх боломж олгох хэрэгтэй аж. Монголын ЖДҮ-ийн зарлагын мэдээллийг хүснэгтээс харна уу.

**Нийслэлийн авто замын засвар үйлчилгээ,** шинээр зам тавих хөрөнгө оруулалтаас хоёр жилээр хоцорсон гэх судалгааг Дэлхийн банкнаас гаргажээ. Энэ нь шинэ зам барих төсвийг батлахдаа замын засвар үйлчилгээний өртгийг давхар тооцдоггүйтэй холбоотой аж. Замын насжилтыг уртасгах гол үндэс нь засварын ажил байдаг.



Эх сурвалж: СЯ болон УСХ-ны өгөгдөл



**ЖДҮ-ийн хариулсан хувиар**

Түүхий эд	42.5	31.4	33.4	38.8	39.3	25.4	33.1
Цалин	15.8	24.2	22.0	18.6	23.2	17.6	16.6
Бусад	21.8	15.4	9.9	15.8	31.8	35.1	10.7
Хуримтлал	16.4	19.3	12.8	11.0	10.6	20.3	11.6
Ажлын байрны түрээс	13.1	15.2	13.1	10.7	7.5	7.6	7.6
Тоног төхөөрөмж, технологи	8.9	10.9	8.1	10.4	13.2	22.2	14.1
Зээлийн хүү	10.8	12.1	12.6	9.3	7.8	13.9	10.5
Тээвэр	11.9	10.0	7.1	8.3	10.1	20.8	12.7
Татвар	8.9	8.7	8.9	8.8	10.1	20.8	12.7
Эрчим хүч	6.1	7.4	6.6	6.4	6.2	9.6	6.9
Хураамж, шимтгэл, төлбөр	6.3	6.6	6.2	4.9	6.1	9.8	4.0
Дулаан, ус	5.5	6.9	6.2	4.8	3.9	7.3	7.0
Харилцаа холбоо	5.5	5.5	4.1	3.8	3.9	4.6	4.1

Засвар үйлчилгээний зардал, шинэ замын хөрөнгө оруулалттай харьцуулсан үзүүлэлт



## ДЭЛХИЙ ДАХИНД

**“Роснефть”** 2018 он гэхэд Хятад руу экспортлох газрын тосны хэмжээгээ 34-50 сая тонноор нэмэгдүүлэхээр (өдөрт нэг тонн баррель газрын тос) болсныг Ройтерс агентлагаас мэдээлжээ. Ингэснээр Хятад улс Оросын газрын тосны хамгийн том импортлогч болох юм. Газрын тосыг Казахстан, Козминогийн боомт болон Зүүн Сибирь-Номхон далайгаар дамжуулан зөөвөрлөх аж.

**Хятадын цахим худалдааны борлуулалт** 2020 он гэхэд жилд 420 тэрбум ам.долларт хүрнэ гэх урьдчилсан тооцоо гарсан. Энэ нь тус улс жижиглэнгийн худалдааны дэлхийн хамгийн том зах зээлтэй орон болох магадлалтайг харуулж байна. Олон улсын менежментийн зөвлөгөөний фирм болох “McKinsey & Co”-ын мэдээлснээр дэлхийн хамгийн олон интернэт хэрэглэгчтэй (одоогоор 500 сая) Хятадын цахим худалдаа 420-650 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй.

**БНХАУ-ын тэнгисийн эрэг хавийн усны чанар өнгөрсөн онтой харьцуулахад** буурсан үзүүлэлттэй гарсан талаар тус орны Улсын тэнгисийн удирдах газраас мэдээлжээ. Өнгөрсөн онд эрэг орчмын 68.000 ам.метр газарт байх усны чанарын түвшин маш муу үзүүлэлттэй гарсан нь 2011 оныхтой харьцуулахад 24.000 ам метрээр нэмүү тоо юм.

**Японы худалдаа** сүүлийн найман сарын туршид тасралтгүй унасан нь шинэ Засгийн газарт сорилт болж байна. Экспорт өнгөрсөн сард буурсан бол импорт өсч, худалдааны алдагдал 777.5 тэрбум иенд (8.1 тэрбум ам доллар) хүрэв. Японы Сангийн яамнаас “Экспорт хоёрдугаар сард өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.9 хувиар буурсан, харин импорт 11.9 хувиар өссөн” гэж мэдээлжээ.

### Европын холбооны

удирдагчид 2013 оны гуравдугаар сарын 28-наас евро бүсийн уур амьсгал, эрчим хүчний дүрэм, журмын талаар хэлэлцүүлэг эхэллээ гэж “Блүүмберг”-ээс мэдээлж байна. Хэлэлцүүлгийн зорилго нь хүлэмжээс ялгарах хийг бууруулж, цэвэр эрчим хүчний технологийг сурталчлах урт хугацааны төлөвлөгөө гаргах явдал юм. Брюссель хотноо хэвлүүлсэн бичиг баримтад Европын холбооноос “2020 он сэргээгдэх эрчим хүчний хэмжээг

нэмэгдүүлж, хүлэмжийн хийг бууруулахын төлөө Европын холбооны 27 орон урагшилж байгаа ч хөрөнгө оруулагчдын итгэлийг төрүүлэх хууль, эрх зүйн орчин, инновацийн түлхэц болон дэлхийн уур амьсгалын асуудалд бэлтгэх шаардлагатай” гэжээ. Европын холбооны комисс нь бүх гишүүн орон, аж үйлдвэрийн бүлэглэл, төрийн бус байгууллагыг 2030 он хүртэл хэрэгжүүлэх ногоон хөгжлийн саналаа ирэх долдугаар сарын 2-ны дотор хураалгахыг хүсчээ. ■



ОНЦЛОХ

## УУЛ УУРХАЙН ИЛЧ БУУРАВ УУ




**Б.ЭНХМАРТ**  
“Mongolian Economy”  
сэтгүүлийн  
Хариуцлагатай нарийн  
бичгийн дарга

Нимгэн алчуур хүзүүндээ хийсгэж, гоо биеэ гайхуулахыг удтал хүлээсэн охидын хүслийг хясах шиг хаврын салхи хавирга нэвт шилбүүрдэв, өнгөрсөн өдрүүдэд. Үүний нэгэн адил Монголын хөрөнгө оруулалтын орчныг таатай болохыг хүлээж ядсан гадаадын хөрөнгө оруулагчдын амыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж таглалаа. Тэрбээр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг “Нягт, нарийн, чамбай хууль байх ёстой” хэмээн буцаасан нь цөөнгүй хөрөнгө оруулагчийг хөдөлгөөнд оруулав. Дээр нь Монголын эдийн засгийн ноён нуруу гэж болох Оюутолгойн асуудал хүнд байгаа нь нэрмээс болсон хэрэг. Гэхдээ Монголд хөрөнгө оруулалтын орчин нааштайгаар эргэнэ гэсэн итгэл, хүлээлт тэдэнд байгаа. Хамгийн гол нь зарим хөрөнгө оруулагч хууль батлах хүртэл Монголд хоргодоод байх шаардлагагүй болсон нь авчирч мэдэхийг эмтэрч буй эдийн засгаас харж болно.

“Mongolian Economy” сэтгүүл таны гарт хүрч буй шинэхэн дугаартаа уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин, бодлогын тогтворгүй байдал, хөрөнгө оруулагчдын “зангаа хувиргаж буй” дүр төрхийн талаар хөндлөө. Түүнчлэн дэлхийд Монголын нэрийг өчигдөрхөн цуурайтуулж байсан Тавантолгойн ордын “тэг” зогсолт юунаас болсныг манай сэтгүүлч Б.Баяртогтох илчлэв. Мөн Голланд өвчнийг гайхамшиг болгосон Нидерланд улсын Ерөнхий сайд асан Вим Кокын асуудлын гарц, шийдлийг хэлж өгсөн сонирхолтой ярилцлагыг хүргэж байна.

Бид дараагийн дугаартаа төрөлжиж амжаагүй, хөлд орох гэж тэнцвэрээ олж ядаж байсан Монголын эдийн засаг хөрөнгө оруулалтын “тэтгэлэг”-ээс хальтхан хөндийрөх төдийд хэрхэн савлаж, төсөв алдагдалд хүрэх нь хэмээн учир мэдэх бүхэн зовниж, тооцоолсон өсөлт, төлөвлөж байсан бүтээн байгуулалтууд хэрхэн “царцаж” эхэлж буйг, үүнээс ангижирч, сэхээрэх гарц юу байх талаар сурвалжлан хүргэх болно.

Тэртээ холоос дүнхийн харагдах хөхөмдөг уулсын хундан цагаан цас хайлж, уулын суга, судаг бүрээр ус шоржигнон байна. Малчны хотонд төлийн дуу цангинан, халуун намраар хүний нутгийг зорьсон шувууд эх нутгаадаа зэллэнэ. Өвс, ногоо соёолж, байгаль, дэлхий өнгөө засах цаг айсуй. Гэвч Монголын уул уурхайд хаврын хуйсагнуур тэнгэр хэсэгтээ гэрэлт илчээ хайрлахгүй бололтой. Гэхдээ урин цагийн тунгалаг өдөр удахгүй ирнэ гэдэгт эргэлзэхгүй байна. ■



...Уул уурхайгаар халхавчилсан төрөлжөөгүй эдийн засгийн хэврэг дүр төрх илчлэгдэж, төсөв “сандарч” эхэллээ. Нэг талаар сургамж ч, нөгөөтэйгүүр монголчуудын хувьд эрсдэл юм...

АСУУДАЛ

## ЭДИЙН ЗАСАГ

# ЭМТРЭН УНАЖ БАЙНА

Б.МАРТ

Монголын уул уурхай дэлхий нийтийн анхаарлын төвд дахин орлоо. Гэхдээ энэ удаад тодорхой бодлогогүй, хэлснээсээ буцдаг, амлалтдаа хүрдэггүй, бусдыг бөөрөлхдөг, олон ааштай, зохион байгуулалтгүй, итгэлдаах чадваргүйгээрээ мандаж байна. Тодруулбал, тус салбарын хөл, толгой салбарынханд нь ч олдохгүй байна. Уул уурхайн бодлогын залгамж, халаа гэж алга. Зөвхөн уул уурхай ч биш бүх салбар тийм байна. Өмнөх бодлогын сайн, мууг ялгаж, салгахгүйгээр бүгдийг улс төрийн “алчуураар” арчиж байгаа нь энэ салбарын гол дутагдал. Түүхэндээ 91 жилийн настай ч хөгжлийн хувьд дөнгөж хөлд орж буй одоогийн байдал нь тогтсон бодлогогүй, чиглэх зүггүй байгааг нь илчилнэ. Үүний дээр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд стратегийн ач холбогдолтой

ордуудын зохицуулалтыг тодорхой тусгаж өгөөгүй, хэзээ, хэдийг нь ашиглаж, хэрхэхийг заагаагүй нь хөрөнгө оруулагчид хийгээд энэ салбарынхныг улам бүр төөрөгдөлд оруулж байна. Шинжээчид Монголыг Голланд өвчний хүнд хэлбэрт орсныг тодорхой бодлогогүй, зөв чиглэлгүй, олон эзэнтэйн балаг хэмээн тодорхойлж байна. Ойлгомжгүй, тодорхойгүй хууль, журмын “дэмжлэг”-тэйгээр гадаадын хөрөнгө оруулагчдын олонх нь Монголоос “залхаж”, зарим нь зугтаж, улмаар олон арван төсөл, хөтөлбөр гацаж, эдийн засаг захаасаа эмтэрч эхэллээ.

Монголд уул уурхай хэрэгтэй юү? Одоогийн нөхцөл байдал ингэж асуухад хүргэж байгаа. Өдгөө ДНБ-ий 25, экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаар бүрдүүлж байна. Сангийн яамнаас энэ оны ▶


▶ эдийн засгийн төсөөллийг 17 их наяд, төсвийг долоон их наяд төгрөг байхаар төсөөлсөн. Мөн энэ онд Монгол эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд хоёрт давхина гэсэн “зар” өнгөрсөн оны сүүлчээс тарсан. Үүний гол мотор нь уул уурхай, тэр дундаа Оюутолгой. Гэтэл уул уурхайн гадаадын хөрөнгө оруулалт хийгээд дотоод дахь үйл ажиллагаа зогсонги байдалд орчихлоо. Яагаад?

Зургаа дахь удаагаа шинэчлэн найруулж буй Ашигт малтмалын тухай хууль хэрхэн чамбайрахыг монголчууд төдийгүй дэлхий нийт хүлээж байна. Ерөнхийлөгчийн санаачилгаар гарсан Ажлын хэсгийнхэн сул, задгай явж ирсэн байгалийн баялаг, эрх зүйн орчин, хараа хяналтыг нэлээд чангалахаар сайн, муугаа хэлүүлэн ажиллаж буй. Шинэчлэлийн Засгийн газар Уул уурхайн яам байгуулж, тархай бутархай бодлогын хэлтсүүдийг нэгтгээд байгаа. Салбарын сайд Д.Ганхуяг шинээр төрөх болон одоо хэрэгжиж буй хууль, дүрмийг сахиулах, уул уурхайн гэгдэх бүхнийг эмхэтгэхийн тулд 80 ажлын хэсэг томилж, өнгөрсөн сарын байдлаар 36 нь гүйцэтгэлээ мэдээлж байв. Энэ үеэр Д.Ганхуяг Ашигт малтмалын тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа УИХ-аар хэлэлцэх байх гэсэн юм. Тэр хүртэл хүлээхийг хүсээгүй гаднынхан хөрөнгөө хумьж, энэ хавраас өрнөнө хэмээн тооцоолж байсан олон арван төсөл, хөтөлбөр гацаж, зарим нь буцаж байна.

Гаднын зарим хэвлэлд “ЗМ-ийн нэг хасагдлаа. Монгол гадаадын хөрөнгө оруулагчдад хатуурхаж эхэллээ” зэрэг мэдээллүүд гарч эхэлсэн нь манайхыг чиглэсэн хөрөнгийн урсгалыг хааж, үүн дээр нь Оюутолгойн хувь нийлүүлэгчдийн хурал зэрэг ээдрээт асуудал тэдэнд Монголын эдийн засаг дордож магадгүй гэх хардлагыг төрүүлж байна. Үүний “ачаар” уул уурхайгаар халхавчилсан төрөлжөөгүй эдийн засгийн хэврэг дүр төрх илчлэгдэж, төсөв “сандарч” эхэллээ. Нэг талаар сургамж ч, нөгөөтэйгүүр монголчуудын хувьд эрсдэл юм.

## Хөрөнгө оруулагчдын “дүрвэлт”

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь гаднын хөрөнгө оруулагчдыг, үргээсэн маш муу хууль боллоо гэх зэмлэл жил гаруй үргэлжилж буй. Энэ талаар Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн зөвлөлийн дарга, “Алтан Дорнод Монгол” компанийн гүйцэтгэх захирал Б.Болд “Хятад, Австрали, Өмнөд Африк, ОХУ тэргүүтэй манайхаас хэд дахин



Лиценз эзэмшигч улсуудын нэгдсэн тоо

БНХАУ	232	УНГАР	2
ОХУ	248	БОЛГАР	8
Япон	141	БАГАМИ	98
АНУ	12	ФРАНЦ	14
Англи	443	Ирланд	1
БНСАУ	70	БЕРМУД	156
КАНАД	76	Люксембург	8
Герман	16	Шинэ Зеланд	36
Украин	3	АНТИГУА БАРБОДА	30
Чех	4	КАЙМЕНИЙ АРУУД	59
Австрали	28	МАЛАЙЗ	1
		БЕЛЬГИ	1

илүү баялгийн нөөцтэй орон зөндөө байна. Тэгэхэд бид зөвхөн Монголд л байгаа юм шиг ашиг болж болохгүй. Одоогийн Засгийн газар бодлогоо тодорхойлж байгаа нь сайшаалтай. Гэхдээ бодит байдлыг зөв үнэлж, зөв бодлого гаргах нь бидэнд ашигтай. Өмнө нь ч хууль, журмын дагуу ажиллаж ирсэн. Түүнээс биш хууль журамгүй, хулгайгаар нүүрс, алт, зэс олборлоод байсан юм байхгүй. Хамгийн гол нь эрдэс, баялгийг металлээр нь ангилж, хөрөнгө оруулагчдыг стратеги, хөрөнгө оруулалтын гэх мэтчилэнгээр төрөлжүүлэх нь манай нөхцөлд одоо шаардагдаж буй асуудал. Мөн үндэсний уул уурхайг татварын зэрэг бусад бодлогоор өндийлгөх хэрэгтэй” гэв.

Мөн Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн гишүүн Д.Ачит-Эрдэнэ “Монголын эрх ашиг, ирээдүйн төлөө аливаа хуулийг шинэчлэн, найруулдаг. Харин ингэхдээ тухайн цаг үед тохирсон, ирээдүйд халтай зүйл хийж болохгүй. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг цаг үеийг нь олж, маш мэдрэмжтэй хийх нь чухал. Хөрөнгө оруулагчид өнгөрсөн оны зургадугаар сараас Монголын хөрөнгө оруулалтын орчин таагүй боллоо гэж ойлгож ▶



Олгосон лицензийн тоо, хэмжээ хязгаараа алдсан

"Монголресорсес эксплорейшн" компани-Д.Самбалайбат 247  
 "Кью-Жи-Эс монгол лимитэд" компани-Б.Ганбат 131  
 "Адамасмайнинг" компани-З.Номундарь-119  
 "Айвенхоу Майнз" компани -Пол Чер-117  
 "Бату майнинг монгол" компани-Жон Даглес Макгей-110  
 "Алтан дорнод" компани-С.В.Паушок-90  
 "Тедфис майнинг" компани-Фабио Сангайёо Мазотти-75  
 "Галлантинерад монгол" компани-Кийс Ласковский-71  
 "Азия гоулд монголиа" компани -Дэвид С Одэнс-67  
 "Жен Юан" компани-Ли Хун Си-14  
 "Деронгмонголиа" компани-Тиэн Гуан Гу-9

Эх сурвалж: Уул уурхайн яам

▶ эхэлсэн. Бизнес, санхүүгийн салбарт ажилладаг хүмүүст одооноос илт мэдрэгдэж байна. Мөн Монголд үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хувьцаа эрс унасан. Монголын компаниуд гадаадын хөрөнгийн бирж дээр энэ жил IPO бараг хийсэнгүй. Монголд хөрөнгө оруулалтын орчин муудсан гэх ойлголт байгаа учраас хувьцааг нь авахгүй байна. Бондын зах зээл ч ялгаагүй. Монголоос гаргасан бондын хүү дөрвөн хувь байснаа тав болж өссөн. Улсын эрсдэлийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 25 хувиар ихэссэн. Түүнчлэн манайд үйл ажиллагаа явуулж байсан хөрөнгө оруулалтын хэд хэдэн сан үйл ажиллагаагаа зогсоогоод явчихлаа. Одоо Европын сэргээн босголтын банк, Хөгжлийн банкаас өөр хөрөнгө оруулагч бараг байхгүй болсон" гэсэн юм.

Судлаач, эдийн засагчдын санааг хөрөнгө оруулагчдын "дүрвэлт" илт зовоож эхэллээ. Үүнд, Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүү "Энэ бол хариуцлага ухамсарлах, өндөржүүлэх асуудал юм. Хариуцлагагүй, сул задгай явж ирсэн компаниудад бол боломжийг нь нэлээд хааж байгаа чанга хууль. Харин хариуцлагатай,

хариуцлагатай байхыг эрмэлздэг, сахилга баттай компаниудын хувьд асуудал биш. Бид Монголд, үр хойч, ирээдүйдээ хэрэгтэй, ашигтай хууль бий болгохоор л ажиллаж байна. Монголын хууль гаднынханд хэт өгөөжтэй, бүхнээ дэлгэж болохгүй. Бас дэндүү хатуу, түлхэж, боомилж болохгүй. Тодорхой тооны хөрөнгө оруулагч хөрөнгөө татсан тухай мэдээлэл бий. Түүнээс биш хэт олноороо, эдийн засагт мэдэгдэхүйцээр явсан зүйл одоогоор алга. Энэ бол зохицуулалтын асуудал болохоос биш хөрөнгө оруулагчдыг хааж, хавчсан зүйл огт биш" хэмээв. Гэвч бодит байдал бишдсэнийг дэлхий нийт онцолж байгааг мартаж болохгүй. Уул уурхайн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бүхэн гацаанд орж, зарим нь зогсож эхэлсэн нь хуулийн орчноор "оролдсонтой" холбоотой.

Эдүгээ гаднын хөрөнгө оруулагчид, тэр дундаа уул уурхайн бизнесмэнүүд шинээр батлах хуульд сул тал, ашигтай зүйл гарах нь уу хэмээн ажиглахын сацуу бусад улсад хөрөнгө оруулж, мөнгөө эргэлдүүлж эхэллээ. Ус, агаар мэт хэрэгтэй гадаадын хөрөнгө оруулалтыг ингээд "явуулчих" нь хайран ч төрийн бодлого, баялгийн дархлаа бидэнд чухал. Учир нь хуулийн төсөл боловсруулагчид бол Монголын ирээдүйг хамгаалах хоточ банхар байх ёстой. Энэ утгаараа гаднын хэн нэгний таашаалд нийцүүлж, хууль, журам, дүрэм батлах эрх бидний хэнд ч байхгүй. Гаднынхан болоод дотоодынхонд нэн таатай, эрх зүй сул, хяналт муу орчинтой байсныгаа бид засаж, сайжруулж, өөрийн өмчөө хамгаалах гэж байгаа учраас эмээх зүйл үгүй гэж тайвширч болно.

Гэхдээ бас газрын дорх баялгаа ухаад гаргах техник, багажгүй гар хоосон, хөл явган монголчууд нэг талыг хэт барьж болохгүй. Нэг кг алт гаргахад шаардлагатай зүйлсийн 90-95 хувийг хөрөнгө оруулагчдаас "харж" байгаа бидэнд уян хатан бодлого хэрэгтэй. Энэ нь хуулийн хүрээний зөв зохицуулалт. Түүнээс биш шавхагдах баялгийн төлөө үр хойчдоо өр, ахиад л таван жилийн дараа засах хуулийн төсөл бэлдэх хэрэггүй. Зөв зохицуулалт руу тэмүүлж байгаагийн нэг жишээ нь, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг тэргүүтэй гишүүд Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 4.7 дугаар заалтыг өөрчлөх төслийг УИХ-ын дэд дарга М.Энхболдод өргөн барьсан явдал юм. Өнгөрсөн оны тавдугаар сард баталсан дээрх хуульд 100 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болон тухайн аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хэмжээ 49 хувиас дээш байх тохиолдолд УИХ-аас зөвшөөрөл авч хөрөнгө оруулахаар заасан. Энэ нь хөрөнгө оруулалтыг саналаар хийх хүсэл, эрмэлзлийг багасгах, ▶

## Шавраас нэр хүндээ татаж гаргаач

Уурхайчин. Монголынхоо баялгийг харийнханд цөлмөн өгөгч, байгаль, дэлхийгээ эвдэн сүйтгэгч, хууль бусаар баялаг хулгайлагч, нинжа, бичил уурхайчин гээд орчин цагийн уурхайчдад сайн нэр нэг үгүй. Энэ мэргэжлээр ажил, амьдралаа авч яваа настайчууд “уурхайчин” гэхээсээ ичдэг болтлоо энэ салбарын нэр хүнд унасныг олон хүн ярьдаг. Тэгсэн атлаа салбарын ачаар эдийн засгаа төрөлжүүлэх, зам, сургууль, цэцэрлэг, тэнгэр баганадсан барилга, хөгжил ирнэ гэж найдаж, хүлээж суугаа. Энэ салбарын хөсөр унасан нэр хүнд, имижийг бодлогоор сэхээн амьдруулах цаг нь энэ үе байх ёстой.

► өрөмдлөг, тээвэрлэлт зэрэг жижиг, сажиг асуудал бүрийг УИХ хэлэлцэж, шийдвэр гаргахад хүрч байгааг онцолж, 100 тэрбум төгрөгийн босгыг арилгах, УИХ-аас 49 хувиас дээш зөвхөн төрийн өмчит болон оролцоотой аж ахуйн нэгжийн холбогдох хэлцлийг шийдвэрлэх тухай төсөл юм. Үүнийг гадаадын хөрөнгө оруулагчдын нуруунаас нэг том ачааг авч хаяна гэдэгтэй санал нийлэх хүн цөөнгүй байна.

Мөн геополитек болоод гуравдагч хөршийн харилцааг орхигдуулж болохгүй. Зарим эх сурвалжид гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудал бол дотоод зах зээлээ хамгаалах арга гэжээ. Үнэндээ бол манайд хамгаалаад байх зах зээл одоогоор бүрэлдээгүй байна. Энэ өнцгөөс байдалд хандаж байгаа бол цаг нь арай эрт гэдгийг бидний дотоодоо хангах ямар нэг бараа, бүтээгдэхүүнгүй байдал гэрчилнэ. Гаднын хөрөнгө оруулагчдын хөрөнгөөр хийж, бүтээх, амжуулах, туслалцаа авах шаардлага дөнгөж бууриа засаж буй монголчуудад юу юунаас хэрэгтэйг бодлого боловсруулагчид мартаагүй байх. Япон, Герман зэрэг гүрнүүд улсдаа хөрөнгө оруулалт татах гэж яаж тэмцэлдэж байгааг бид бэлхнээ харж байна. ДНБ нь 50.000 ам.долларт хүрсэн хэрнээ АНУ гадаадын хөрөнгө оруулалтыг яаж дэмжиж, хаалгаа нээж байгаа нь ч цаанаа учиртай. Төрийн тодорхойгүй байдал, ойлгомжгүй олон хууль, дүрэм, журмаас болж шувуу шиг үргэсэн хөрөнгө оруулагчдыг Ашигт малтмалын тухай хуулийг шинэчилж баталснаар эргүүлээд аваад ирнэ гэвэл үлгэр болно. Тиймээс одоо л бидний зүрхээ чагнах цаг.

Хэрвээ бид аль нэг улсын төрийн бодлого манайд буурь засахаас сэргийлэх гэж байгаа бол Канад, Австрали шиг “Аливаа улсын бодлогоор орж ирж байгаа төрийн өмчлөлтэй аж ахуйн нэгжийг Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлж, зөвшөөрөл өгнө” гэж тусгах хэрэгтэй. Түүнээс биш орж ирснийх нь дараа “Чалко” шиг буцаах нь Монголын нэр хүнд хийгээд бизнест халтай. Үүний хажуугаар гаднын хөрөнгө оруулагчид бидний баялагт хэрхэн эзэн суусныг мартаж болохгүй.

### Юун эдийн засгийн тогтвортой өсөлт, амьдралын баталгаа, ажлын байр

Тэргүүлэгч салбарын халаас, нүд, чих, аман дээр сандалчихаад байгаа улстөрчдийн ашиг сонирхлын ган гинжийг

таслах цаг иржээ. Оюутолгой, Тавантолгойг улстөржилтийн савраас даруй “аврахгүй” бол хууль, дүрэм батлаад ч тусыг олохгүй. Бид төсвийнхөө дийлэнхийг энэ салбараас тэр дундаа Оюутолгойоос бүрдүүлнэ гэж төсөөлж буй. Ирээдүйнхээ ихэнх хувийг Тавантолгойн нүүрсэнд даатгаад буй. Гэтэл бидний хувьд алтан өндөг гаргадаг тахиагаа төрийн оролцоотойгоор буланд шахаж, эвгүйдвэл алж ч мэдэх нөхцөл бүрдээд байгаа. Эндээс Монголын эдийн засаг маш эмзэг, ганцхан зүйлээс хараат, төрөлжиж чадалгүй “нүд аньж” мэдэхээр байгааг дүгнэж болно. Юун эдийн засгийн тогтвортой, огцом өсөлт, ажлын байр, амьдралын баталгаа.

Оюутолгойн гэрээнээс урьтаж монголчуудыг ордын 34-өөс илүү хувийг эзэмших эрхгүй болгож, алт, зэсийн гэнэтийн ашгийн 68 хувийн татварыг хүчингүй болгосон гээд улс төрийнхний бантан дуусахгүй.

Монгол Улсад нөөц нь тогтоогдсон 1200-гаад ордоос 200-300-г нь стратегийн ордод хамруулах боломжтой ч 15 нь “Стратегийн орд” хэмээн зарлаж, хавсралтаар 39-ийг нэрлэсэн байдаг. Монголын төр, ард түмэн хувь хүртэхээр хуульчилсан ч дээрх ордууд аль хэдийн дотоод, гадаадын хувийн компаниудын мэдэлд орж, түрүүчээсээ олборлож дуусаад байна. Тэр ч бүү хэл стратегийн ордуудын лиценз нь хувь хүмүүсийн гарт орж, Хонконг, Торонто, Лондонгийн хөрөнгийн биржид задгай мөнгө шиг зарагдаж байна. Лицензийг дагаад тухайн газарт байгаа баялаг тэр чигтээ гадаадын хувьцаа эзэмшигчдийн мэдэлд очиж байна гэсэн үг. Хавсралтаар дурдагдсан 39 ордыг орхиод, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн 15 стратегийн ордыг л аваад үзье. Нарийн сухайтын нүүрс, Мардай, Гурванбулагийн уран, Төмөртэйн төмрийн хүдэр, Бүрэнхааны фосфорит, Бороогийн алт, Төмөртэйн овооны цайрын орд, Дорнодын Уран гэсэн найман орд Хятад, ОХУ, Канадын мэдэлд бүрэн шилжсэн. “Стратегийн ордод Монголын талын хувь оролцоо 50 хүртэл хувь байна” гэсэн хууль үйлчлэхгүй байгаагаас үлдсэн долоон орд ч энэ замаар явж мэдэхээр байгаа. Дээрх ордуудын заримтай нь Монгол Улс “Тогтвортой байдлын гэрээ” байгуулсан гэдэг ч тэр нь нууц. Тогтвортой байдлын гэрээ байгуулсан бол эхний таван жил орлогын албан татвараас 100 хувь, дараагийн таван жил 50 хувь чөлөөлөгдөхөөр гэрээлсэн ►



Уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ /ам.доллараар/

байдаг. “Тогтвортой байдлын гэрээ” халхавчаар ард түмний хүртэх хувийг үгүй хийгээд зогсохгүй, татвараа ч бүрэн төлөхгүй дархан эрх эдэлнэ гэсэн үг.

Монголын олигархиуд ч зүгээр суусангүй. Стратегийн орд болох Нарийн сухайтын нүүрсний ордыг тав хувааж, нэг хэсэгт нь Хятадын “Чинхуа-МАК”, “Канадын Саусгоби Сэндс”-ийн хоёр уурхай, нөгөө хэсэгт нь Монголын “МАК”-ын хоёр уурхай олборлолт хийж байна. Нарийн сухайтын ордын шууд үргэлжлэл болох 188 сая тн нөөц агуулсан хэсгийг “Овоот Толгойн орд” хэмээн нэрлэж, “Айванхоу Майнз Монголиа Инк”-ийн охин компани болох “Саусгоби Сэндс” эзэмшиж, нүүрс экспортолж байна. Зэс-молибдений Цагаан суваргын ордыг бас л “Монголын Алт” буюу МАК компани 100 хувь өмчилсөн. Стратегийн 15 ордоос Монголын төрд Багануур, Шивээ–Овоо л үлдээд байна. Төрийн эрх мэдэлтнүүдийн аалзны торыг ашиглан булааж авч чадсандаа харийнхан баярлаж суугаа.


Ингээд ч зогсож чадахгүй төсвөө бүрдүүлнэ хэмээн тооцоолж, монголчуудыг тэжээх гол эх үүсвэрээр цоллосон болгоод байсан Оюутолгойд “эрхмүүд” гэнэт нуруугаа харуулж, хэвлэл мэдээлэл, хуулиар балбах атлаа өөр хэн нэгнийг “Манайд хөрөнгө оруулаач ээ, таатай орчин шүү. Манайх төмөр зам тавих гэж байгаа, газрын тосны үйлдвэр барих гэж байгаа, сургууль, цэцэрлэг, зам гээд өч төчнөөн бүтээн байгуулалт хийнэ. Хөрөнгө оруулаач” хэмээн урих нь утагагүй. Монголын улс төр уул уурхайтай бат гагнагдсаныг энэ Засгийн газар салгах үүрэгтэй. Гаднынхан бас нүд, чихтэйг санах хэрэгтэй. Хөрөнгө оруулагчиддаа хэрхэн хандаж буйг бидэнд хөрөнгө оруулахаар зэхэж буй харийнхан хар дансандаа үргэлж тэмдэглэж байгаа. Уул уурхайг өөртөө бэхэлсэн улстөрийн гинжийг таслахтун. Үгүй бол тэд “тэжээгчээ” хэн нэгэнд худалдаж ч мэдэхээр байгааг учир мэдэх хүмүүс ярьж байна.


## “Нүүдлийн шувууд”-аас юу салгах вэ

Хөрөнгө оруулагчид бол нүүдлийн шувууд. Ялгаатай нь оруулсан хөрөнгөө хэд дахин нугалж аваад буцна. Өдгөө Монголд орж ирж буй нийт хөрөнгө оруулалтын 81 хувь уул уурхайн салбарт төвлөрч байгаа ч энэ нь бусад салбар, иргэдэд төдийлэн наалдахгүй байгааг хүмүүс шүүмжилдэг. Тухайлбал, орон нутгийн хөгжил, малчид, сурагчид, бүс нутагт юу хөгжүүлэв, шинэчлэв. Үүнийг Монголын төр эргэж харсан тул хуулийн төсөлд шинэчлэл хийхээр ажиллаж буй гэж иргэд ойлгож байгаа. Энэ талаар Б.Болд “Гаднын хөрөнгө оруулагчдыг үзэн ядсан, зүхсэн байдал амь бөхтэй байгаа нь маш буруу. Монголын тусгаар тогтнолыг улам баталгаажуулсан гаднын том хөрөнгө оруулагч бидэнд хэрэгтэй. Монголын бүтээн байгуулалт, аж үйлдвэр дөнгөж яригдах хэмжээндээ л явж байна шүү дээ. Цаасан дээр байгаа зүйлийг босчихсон мэт сэтгэж, босгох хөрөнгөө үргээх эрх бидэнд байхгүй. Хөрөнгө оруулагчид бол өөрт таатай орчин нөхцөлийг л сонгоно. Монголоос гадна өч төчнөөн таатай орчин байгааг бид мартаж болохгүй” гэсэн.


Мөн гаднынхны туршлага, олон улсад нийцсэн нөхөн сэргээлтийн арга, дэвшилтэт технологиуд бидэнд хэрэгтэй. Дэлхийн стандартад нийцсэн нөхөн сэргээлтийн арга, туршлагыг нэвтрүүлж байна хэмээн олборлогчид тархи угааж байгаа ч газар дээрээ хэрэгжсэн нь хэд л бол. Хяналт, шалгалтын комиссынхны хийсэн шалгалтын дүнд монголчууд итгэж үлдэж байгааг мэргэжлийн байгууллагын ажилтнууд бодох л хэрэгтэй. Зөв зохицуулалтаар хөрөнгө оруулагчдыг дуудаж, тэдний гар, ур ухаан, хөрөнгөөр их зүйл бүтээж, эдийн засгаа нэг баганаар биш төрөлжсөн олон хөшүүргээр тэтгэж, бат бөх болгох нь л энэ хуулийг дахин дахин оролдож байгаагийн гол шалтаг. Түүнээс биш үлээхэд хийсэх, хүрэх төдийд нурах хөрөнгө оруулалт дээр л тогтсон өнөөдрийн байдлыг “тогтоох” учиргүй. Хуулийн сургаар эмтрэн унаж буй эдийн засгаа бид маш түргэн хугацаанд дархлаажуулах хэрэгтэй байна. Үгүй бол юун төсөв, инфляцийг нэг оронтой тоонд оруулах, бондын өр дарах, ДНБ-ээ 30.000 ам.долларт хүргэх талаар яриад ч хэрэггүй бид. ■

# СТРАТЕГИЙН 39 ОРД






Монгол Улсын ашигт малтмалын лицензтэй талбай /2015 оны хэтийн төлөв/



Уул уурхайн салбарын улсын эдийн засагт эзлэх хувь




Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт Оюутолгойн төслөөс шууд хамааралтай болох нь

(их наяд төгрөгөөр)


	2009	2010	2011	2012	2013
Үндэсний нийт бүтээгдэхүүн	6,591	8,415	11,088	14,185	17,649
Өөрчлөлт (номинал)		1,824	2,673	3,097	3,464
Төсвийн орлого	1,994	3,123	4,228	5,530	7,088
Өөрчлөлт (номинал)		1,129	1,105	1,302	1,558
Гадаадын хөрөнгө оруулалт	798	2,152	6,191	5,177	?
Өөрчлөлт (номинал)		1,354	4,039	(1,014)	?
Оюу толгойн хөрөнгө оруулалт	1,092	3,809	3,286	830	
Өөрчлөлт (номинал)		1,092	2,717	(523)	(2,456)
Оюу толгойн эзлэх хувь		51%	62%	63%	

Эх сурвалж: Уул уурхайн үндэсний ассоциаци


Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт ба үйлдвэрлэл




Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, 2008-2013 он




Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбай, сая ректар, 2008-2013 он




Монгол Улсын нүүрсний экспорт 2008-2012 онд  
/мян.тонн/



Монгол Улсын нүүрсний олборлолт  
/мян.тн/




Нүүрсний салбарын өнөөгийн байдал  
/2012 оны жилийн эцсийн байдлаар уул уурхайн салбар/



Монгол Улсын ДНБ-ий өсөлтийн таамаг  
/тэрбум ам.доллр/



Монгол Улсын нүүрсний хэрэглээ



## -Улс төрийн тодорхойгүй байдал уул уурхайн салбарт хэрхэн нөлөөлж байна вэ?



**Д.Ачит-Эрдэнэ**  
/Монголын олон улсын хөрөнгийн корпорацийн ерөнхийлөгч/

### Мөнгөний урсгалыг бусдад алдаж эхэллээ

-Монголд үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцаа эрс унасан. Монголын компаниуд гадаадын хөрөнгийн бирж дээр IPO хийдэг байсан бол энэ жил бараг хийсэнгүй. Хөрөнгө оруулалтын орчин муудсан гэх ойлголт байгаа учраас хувьцааг нь гаднынхан авахгүй байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчид Монголыг сонирхох нь багассан. Үүнд, Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль, улс төрийн орчин, салбарын бодлого нөлөөлсөн. Өнөөдрийг хүртэл шинэ Засгийн газрын уул уурхайн салбарт баримтлах бодлого тодорхой бус байна. Энэ байдал хөрөнгө оруулалтад төдийгүй уул уурхай, эдийн засгийн салбарт сөргөөр нөлөөлөх боллоо. Бодлого тодорхой бус байгаа учраас хүлээлт үүссэн гэж хэлж болно. Монголд хөрөнгө оруулах эсэхээ гаднынхан шийдэж чадахгүй байна.

Монголын хөрөнгө оруулалтын эрсдэлийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 25 хувиар өссөн. Хөрөнгө оруулагчид өнгөрсөн сонгуулийн өмнөөс л хөрөнгө оруулалтын

орчин таагүй боллоо гэж дүгнэж эхэлсэн. Манайхаас хийсэн судалгаагаар гадаадын хөрөнгө оруулалт өнгөрсөн оныхтой харьцуулахад 40 хувиар буурсан байна лээ. Сая л гэхэд манайд үйл ажиллагаа явуулж байсан хөрөнгө оруулалтын хэд хэдэн сан гарлаа. Тэд үйл ажиллагаагаа хумина гэдэг Монголд хөрөнгө оруулалтын таатай орчин алдагдаж байгаа гэсэн ойлголтыг өгөхөөр байна. Хаана өндөр ашиг, таатай орчин байна тэр зүгт мөнгө урсаж байдаг. Монгол Улс нэг хэсэг мөнгөний урсгалыг өөртөө татаж байсан бол үүнийгээ эргээд бусдад алдаж эхэллээ. Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль хөрөнгө оруулагчдыг үргээсэн гэж хэлж болно. Тиймээс шийдвэр гаргагчид олон талын эрх ашиг, харилцааг анхаарсан хууль эрх зүйн тогтвортой орчинг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Тогтвортой, тодорхой хууль эрх зүйн орчин өөрөө хөрөнгө оруулагчдыг татах үндэс болдог. Мөн гадаадын хөрөнгө оруулагчдад Монголын талаар сайн гэхээс илүү сөрөг мэдээлэл түлхүү очиж байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлж байгааг хэлэх нь зүйтэй болов уу.



**Н.Дорждарь**  
/“Нээлттэй нийгэм форум”-ын судлаач/

### Уул уурхайн салбар нь бодлогогүй байна гэдэг том асуудал

-Ашигт малтмалын салбарт асуудал их байна. Үүнийг цэгцлэх цаг болсон. Тус салбарт хэрэгжиж буй хууль эрх зүйн болон татварын орчин, гаднын хөрөнгө оруулалтыг дагасан зохицуулах ээдрээтэй олон асуудал бий.

Тиймээс явж ирсэн бодлогоо эргэн харах цаг болсон юм болов уу. Өмнө нь хэрэгжиж байсан бодлогод бодитоор хяналт тавьж байсан юм уу. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн төсөл, төрөөс уул уурхайн салбарт баримтлах бодлого хүлээлт үүсгэж байна. Манайх цаг их алдаж байна. Үүнээс болж уул уурхайн салбарт буй асуудал даамжрах вий. Уг нь цаг үеэ олсон хуулийн төслийг хэлэлцүүлж байсан ч Ерөнхийлөгч хаврын чуулганд оруулахгүй гэдгээ мэдэгдсэн. Уул уурхайн салбарт тодорхой бодлого, олон талын

харилцаа зохицуулсан хууль чухал. Мэдээж хууль, бодлого гаргахад хугацаа шаардана. Түүний хэрэгжилт ч хугацаа шаардана. Алгуурлаж болохгүй. Холыг харсан төрийн бодлого гаргах хэрэгтэй. Сайн бодлого байхгүй бол түүний ач холбогдол буурна. Хувьцааны ханш уруудах, төслийн явц удаахрах зэрэг асуудлууд үүснэ. Гэхдээ эцсийн дүнд Монгол Улсын эрх ашиг чухал. Түүнийг тооцож бодлого гаргах нь бүр ч чухал. Уул уурхайн салбар нь бодлогогүй байна гэдэг том асуудал. Гэсэн ч илүү сайн бодлого, хууль эрх зүйн тогтвортой орчинг төр бүрдүүлэхийн төлөө ажиллах хэрэгтэй. Уул уурхай шавхагддаг баялаг. Тиймээс Монгол Улсад үр дүн чухал. Мэдээж одоогийн үүсээд буй нөхцөл дунд хугацаандаа хөрөнгө оруулагчдад халтай байж болно. Гэхдээ манайх олон талаараа хөрөнгө оруулагчдад таатай хэвээрээ байгаа. Урт хугацаанд нөхцөл илүү сайжрах байх. Үүний тулд сайн бодлогыг сайтар хэлэлцүүлж, тунгаан шүүж гаргах хэрэгтэй.

## Уул уурхайг өөр өнцгөөс харах цаг болсон

-Бид өөрийн гэсэн төртэй, хуультай, тусгаар улс. Тиймээс өмчийн харилцааг ил тод байлгаж, шударга ёсыг дээдлэх ёстой. Түүнийг дээдлэхийн сацуу амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Өмнө нь бид гэнэн явжээ. Уул уурхайн салбарт мөрөөдлөөр хандаж байсан. Мөрөөдлөөр хандаж байгаа учраас гэнэн бодлого хэрэгжиж байсан гэсэн үг. Гэтэл үүнийг өнгөрсөн хугацаанд болж өрнөсөн үйл явдал буруу гэдгийг нь нотоллоо. Үүнийг ойлгох гэж асар их үнэ төлж байна. 2008-2012 онд нэг тэрбум ам.доллартай тэнцэх санхүүжилтийг зөвхөн сонгуулийн амлалтад өгсөн. Үүнийг өгч бас авч байж буруу гэдгийг улсаараа ойлгосон. "Алт" хөтөлбөрийн дүнд сүүлийн 10 жилийн хугацаанд 200 мянган тонн алт олборлосон байдаг. Үүнээс Монгол Улсад наалдсан зүйл маш бага. Өөрөөр хэлбэл, бодлогогүй явсны гай энэ. Одоо л баялгийн сан байгуулах тухай ярьж байна. Үүнээс гадна бид өөрсдөө баталсан хуулиа хэрэгжүүлж, мөрдөхгүй байна. Үүнээс болж асуудал хууль эрх зүйн дагуу шийдэгдэхгүй байна. Уул уурхайг зөвхөн геологийн ажлын хэмжээнд сэтгэж, уулын инженерийн мэргэжлийн харилцааг зохицуулах

## Монгол Улсад ардчилал, зах зээлийн нийгмээс ухарсан юм байхгүй

-Бодлогогүй төр гэж байхгүй. Ашигт малтмалын салбарт судалгаа, ашиглалтын бодлого байсан. Энэ бодлого хэр оновчтой, улс орны эрх ашигт зохицож байна уу гэдэг асуудал. Сүүлийн 20 жилд ашигт малтмалыг ашиглах, түүнийг судлах бодлого орхигдсон. Нэг үгээр хэлбэл, амьдралд хэрэгжээгүй гэсэн үг. Эндээс үзэхэд Монгол Улсын эрх ашигт нийцсэн зохистой зөв бодлого байсангүй. Улсын эрх ашигт нийцсэн төрийн бодлогыг боловсруулах чигийг Ерөнхийлөгч сая өгч, Уул уурхайн яаманд төрийн бодлого боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Бид өнгөрсөн 20 жилдээ үнэлэлт дүгнэлт өгөх цаг болжээ.

Монгол Улсын газар нутагт 4000 гаруй лиценз байна. Түүний 1255 нь ашиглалтын лиценз. Лиценз нь 40-50 төрлийн ашигт малтмал олборлох эрхтэй. Өөрөөр хэлбэл, Монголд 1255

хүрээнд хууль, эрх зүйн орчинг тодорхойлж явсны хор уршиг гарч байна.

Монголд нийгмийн олон талын харилцааг зохицуулдаг, түүнийг эрхийг хамгаалж байдаг хууль эрх зүйн бодлого үгүйлэгдэж ирсэн. Хууль гэдэг төрийн бодлого байдаг. Гэтэл төрийн хуулийн амин сүнс болсон бодлого алга байна гэдэг тухайн хууль амьдрах чадваргүй гэсэн үг. Бодлого байхгүй учраас Ашигт малтмалын тухай хуулийн төслийг Ерөнхийлөгч сая буцаалаа шүү дээ. Газрын хэвлийн баялаг бол нийт ард түмний өмч. Гэтэл түүнийг хэдхэн хүн өөрийн өмч шиг захиран зарцуулж, хөрөнгийн зах зээлээс мөнгө босгож ирлээ. Энэ байдал өмнө нь нэг хүний бизнес байсан бол одоо дэлхийн зах зээл рүү гараад явчихсан. 2009 оны үед 26 лицензээр 32 тэрбум ам.долларын хөрөнгө босголоо гэж ярьж байсан. Өмч нь биднийх байгаад байдаг. Уул уурхайн салбарт өмчийн асуудал үүсэж байна. Төрийн нийтийн хамааралтай өмчийн хууль эрх зүйн орчин манайд хангалтгүй байгаа. Мөн хөрөнгө оруулалтын сайн бэлтгэгдсэн мэргэжилтэн алга. Уул уурхай бол эдийн засаг. Тиймээс өөр өнцгөөс харах цаг болсон. Газрын хэвлийн баялаг бол цэвэр эдийн засгийн асуудал болж байна. Үүнийг даанч манайхан дөнгөж саянаас ойлгож эхэллээ. Геологи, уул уурхайн салбарт нь бодлого байхгүй учраас уул уурхайн хаачих гээд байгаа нь ойлгомжгүй байна.

уурхай байна. Төрийн бодлого байхгүй байгааг дээрх тоо харуулж байна. Өнөө үед ийм тооны уурхай байгуулах үндэслэл байхгүй. Манайх геологийн судалгааг бүр мартсан. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, түүнийг ашиглах, үүний үндсэн дээр Монгол Улсыг хөгжүүлэх бодлого 1996 оноос хэрэгжиж эхэлсэн. Монгол Улсад ардчилал, зах зээлийн нийгмээс ухарсан юм байхгүй. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад буруудах үндэс байхгүй. Аливаа улсын хөгжих үндэс бол гадаадын шилдэг тэргүүний технологи дээр үндэслэсэн гадаадын хөрөнгө оруулалтыг татах. Тэр тусмаа Монгол Улсын хувьд ашигт малтмалын баялгаар эдийн засгаа хөгжүүлнэ гэсэн энэ үед хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг тодорхойлсон. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулалт гэсэн нэрийн дор өрөөсгөл, туйлширсан байдал газар авч байна. Монгол болон гадаадын хөрөнгө оруулагчийн эрх ашиг гэж бий. Энэ эрх ашгийг зөв хослуулах нь хамгийн чухал юм. Зөвхөн харилцан ашигтай ажиллах шударга нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.



**Б.Лхагважав**  
/Үндэсний Соёмбо  
хөдөлгөөний тэргүүн/



**С.Авирмэд**  
/Уурхайн инженер-эдийн  
засагч, доктор/



ТӨСӨЛ

# ТАВАНТОЛГОЙД ГАРЦ ХАЙСААР

Б.ТОГТОХ

Төмөр замын гацаа баялгийн гацаа болж хувирлаа. Үүний амьд жишээ нь Тавантолгойн орд. Жилийн өмнө уул уурхайн салбарынхан төдийгүй гадныхны харцыг булааж, хайрыг татаж байсан Тавантолгойн орд хаачив. Энэ хавар олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа арилжаалах байсан “Эрдэнэс Тавантолгой” компани санхүүгийн мухардалд орж, олборлолтоо түр зогсоолоо. Энэ байдлаараа 2016 онд Тавантолгойн ордоос жилд 20 сая тонн нүүрс олборлох төсөөлөл биелнэ гэхэд бэрх. Уг ордыг эзэмших төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани анх ярьж байсан үйл ажиллагааны хөтөлбөрөө баллуурдаж эхэллээ. Уг нь бол 1072 ширхэг хувьцааг нэрийн дансандаа байршуулсан, эс байршуулсан иргэн бүрт Тавантолгой төсөл хамаатай.

Дэлхийн коксжих нүүрсний томоохон сав нутагт байрлах Тавантолгой стратегийн орд. Гэтэл тус ордоос монголчууд хөгжил хүлээх биш, байнгын өр зээлийн асуудал чих халууцуулах болов. “Эрдэнэс Тавантолгой” компани Хөгжлийн банкнаас 300 сая ам.доллар, “Голомт” болон Худалдаа хөгжлийн банкнаас 131 сая ам.доллар

зээлээд байна. Энэ мэт таагүй мэдээллийн хариуд тус компанийн удирдлагын зүгээс “Ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааны зардлаа нөхөхийн тулд” гэсэн тайлбарыг өгөх аж. Тавантолгойн хур өр улам зузаарч, төслийн хэрэгжүүлэх хугацаа товлож байснаас хойшилсоор.

Хятадын “Чалко” компаниас 350 сая ам.доллар зээлсэн Тавантолгой орд 7.4 тэрбум боломжит нүүрсний нөөцтэй. Тус нөөцийг түшиглэн 2015 онд багтан олон улсын хөрөнгийн зах зээлд “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг гаргана хэмээн Уул уурхайн сайд Д.Ганхуяг мэдэгдсэн. Хэрэв уул уурхайн сайдын мэдэгдэл биелэлээ олбол олон улсын хөрөнгийн зах зээлд Тавантолгой орд ойрхон иржээ гэж дүгнэж болохоор. Гэтэл “Дэд бүтцийн асуудлаа шийдвэрлэж чадаагүй тохиолдолд хувьцаа үнэд хүрэхгүй” гэж Монгол нүүрс ассоциацийн гүйцэтгэх захирал Т.Наран учирласан юм.

Дэлхийн нүүрсний зах зээлд тодорч буй Тавантолгой ордын нэр хүнд ганцхан жилийн дотор өвдөг шороодсон гэх. Өнөөдрийн байдлаар ордын Баруун Цанхийн талбайд стратегийн хөрөнгө оруулагчийг тодруулах ▶

► ажил удааширч байна. Үүнийг дэлхийн зах зээлд нүүрсний үнэ унасантай холбон тайлбарлаж буй. Тавантолгойн ордын Зүүн Цанхийн хэсгийн экспорт зогсонги байдал орж, санхүүгийн бэрхшээлтэй тулгарсан гэдгээ “Эрдэнэс Тавантолгой” компанийнхан хүлээн зөвшөөрсөн. Тиймээс Чингис бондын 1.5 тэрбум ам.доллараас төслийг санхүүжүүлэх хүсэлтийг тавиад буй. Уг төслийг хэрэгжүүлэх Засгийн газрын ажлын хэсэг “Таван толгой ордын дэд бүтцийг ойрын хугацаанд хөгжүүлэх ёстой” гэсэн шийдвэр гаргасан. Өөрөөр хэлбэл, талууд Тавантолгой төслийг хөдөлгөх зүтгүүр нь төмөр зам болохыг онцолсон.

Төслийн хэрэгжилт удааширч буй нь Монгол Улс боломжит зах зээлээс өөрсдийн хүсэлтээр татгалзаж байгаатай ижил. Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Тавантолгой” олборлолтоо зогсоосон нь сайн дураараа замаас гарч буй алхам болохыг Т.Наран хэллээ.

“Эрдэнэс Тавантолгой” компани хэцүүхэн байдалтай тэсэж байна. Тэд Засгийн газрыг царайчилж, хөрөнгө оруулагчдад найдлага тавьсан харц чулуудсаар. Нүүрсний зах зээлд Тавантолгойн ордыг сойж буй тус компани өртэй хэрнээ өгөөмөр зантай. Өрөнд баригдсан хэрнээ Засгийн газраас 350 сая ам.доллар зээлж чадвал иргэн бүрт ноогдох 1072 хувьцааны ногдол ашгийг тараана гэж “томорсон” удаа ч бий. Дахиад л алдаагаа давтах вий дээ. Нэг тонн нүүрсээ “Чалко” компанид 70 ам.доллараар үнэлсэн “Эрдэнэс Тавантолгой” компани 500 гаруй сая ам.долларын алдагдал хүлээсэн. Өнгөрсөн онд нүүрсний зах зээлийн үнэ 30 орчим хувиар буурсан. Мөн эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээлийн эх үүсвэрийн 60 гаруй хувийг “Хүний хөгжил сан”-д төвлөрүүлсэн, БНХАУ-ын “Чалко” компанитай байгуулсан гэрээ зэрэг гадаад болон дотоод хүчин зүйлээс хамаарч тус компанид дээрх хэмжээний эрсдэл учирсан. Өрийг төлөх, төслийг цааш үргэлжлүүлэх үүргийг тэд бас хүлээсэн.

“Чалко” компанитай байгуулсан гэрээг “Эрдэнэс Тавантолгой” компани Засгийн газрын түвшинд хэлэлцүүлэхээр зүтгүүлсэн ч

хараахан үр дүнд хүрээгүй байна. БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ван Шао Лун “Чалко компанитай байгуулсан гэрээг анхнаас нь харилцан ашигтай байхаар байгуулсан. Иймд энэ гэрээний хэрэгжилтийг хангахын төлөө байр суурьтай байна” хэмээн мэдэгдсэн. Тэрбээр, “Шинхуа” группийг Тавантолгойн баруун Цанхийг ашиглах тендерт оролцохыг дэмжиж байгаагаар ч давхар илэрхийлсэн юм.

Засгийн газраас 350 сая ам.доллар “нэхэж” буй Тавантолгой төслийн явц хэзээ ашиг тусаа өгөх нь эргэлзээ төрүүлсээр байна. Хүн бүрийн хүндлэл хүлээж явсан урьдын Тавантолгой мөн үү гэмээр. Үйл ажиллагааны зардлаа нөхөж чадахгүй, алдагдал үүрч буй Тавантолгой төсөл өнгөрсөн хугацаанд даанч ажиггүй явж. Монголын хүчирхэг компани байх боломж “Эрдэнэс Тавантолгой”-д бий. Гэтэл Тавантолгойн төсөл санхүүгийн сул дорой байдалд ороод буй нь муу менежменттэй холбоотой гэж үзэх нэг нь ч байна. Түүнчлэн төслийн хэрэгжилтийг хэт улстөржүүлж байгааг салбарынхан учирлах болсон. Хэсэгтээ л сэргэж чадахгүй байх өрийн дарамтад сөхрөөд буй Тавантолгойн ордын Баруун Цанхийн талбайд “Хишиг Арвин Индустриал” компани хөрс хуулах ажлыг гүйцэтгэж байна. “Эрдэнэс Тавантолгой” компани өнгөрсөн онд Зүүн Цанхиас 2.5 сая тонн нүүрс олборлосон бол энэ жил хоёр Цанхиас нийтдээ долоон тонн нүүрс олборлоно гэж тус компанийн гүйцэтгэх захирал Я.Батсуурь хэлсэн.

2011 онд Тавантолгой төслөөр улс төр, эдийн засаг, уул уурхайн салбарынхан “амьсгалж” байсан. Энэ үед “Эрдэнэс Тавантолгой” компанийн Баруун Цанхид олборлолт явуулах тендерийн хэлэлцээр өрнөж байв. Тус ордод олборлолт явуулах шалгаруулалтад АНУ-ын “Peabody Energy”, Хятадын “Shenhua Energy” болон Японы “Mitsui & Co” компаниудын консорциум, “Оросын төмөр зам” болон Японы консорциум, БНСУ-ын “Корес” группээр ахлуулсан компаниудын нэгдэл, Австралийн “Xstrata coal”,

Бразилийн “Vale”, Люксембургийн “Arcelor Mittal” тунаж үлдээд байсан цаг. Ердөө л нэг жилийн өмнө “Эрдэнэс Тавантолгой” компани гарц хайх бус Тавантолгойн ордоор гангарч явсан. Уг орд хөрөнгө оруулагчдад төдийгүй гаднын орнуудад Монголын том сурталчилгаа болж байв.

Саад бэрхшээл, санхүүгийн дарамт, зах зээлийн уналтад “чөдөрлүүлсэн” Тавантолгойн төсөл нэг л явж өгөхгүй байна. Төслийн хэрэгжүүлэлтэд улс төрийн шахалт сөргөөрнөлөөлснийгүгүйсгэхаргагүй. Үүгээр зогсохгүй Тавантолгой төсөлд олны толгойг эргүүлсэн олон асуудал бий. Иргэн бүртээ бэлэн мөнгө тараасан хамтарсан Засгийн газрын бодлогогүй алхам Тавантолгойг өнөөдөр хэн ч биш болгосон. Өрөөс өр, зээлээс зээлийн хооронд гүйх өчүүхэн амьтны дүрд түүнийг тоглуулж дөнгөлөө. Үүнийг тэд хүсээгүй байж мэднэ. Гэхдээ хэлсэн үгэндээ эзэн болох гэж, сонгуулийн амлалтаа биелүүлсэн гэж итгүүлэхээр Тавантолгойн ордоор баярын ширээ засуулсан. Дэлхийн хэмжээний үлэмж ордоор улс төр хийж болдгийг тэд бас харуулж чадсан.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг хэдэн сарын өмнө “Чалко”-той байгуулсан ашиггүй гэрээг цуцалж, бондоор төлбөрийг нь төлөөд, өөр газартай гэрээ байгуулъя. Үүний дараа “Эрдэнэс Тавантолгой” хөл дээрээ зогсоно” гэж мэдэгдсэн. Ерөнхий сайд “Эрдэнэс Тавантолгой”-н ирээдүйд итгэл дүүрэн байгаа. Уул уурхайн сайд Д.Ганхуяг “Гарц хайж байгаа” гэсэн. Үүнтэй зэрэгцэн Тавантолгойн ордыг түшиглэн барих станцын төслийн багийг МҮАН-ын дарга М.Энхсайхан ахалж ажиллахаар боллоо. Уг станцыг барих ажлыг эхлүүлэхээр 50 сая ам.долларыг бондын хөрөнгөөс зарцуулах шийдвэр Засгийн газраас гарлаа. Үүнийг Тавантолгойн төслийг гацааг арилгах гарц гэж үзэж болох юм. Мөн төсөлд шаардлагатай хөрөнгийг 1.5 тэрбум ам.доллараас гаргах эсэх асуудлыг ирэх хаврын чуулганаар УИХ хэлэлцэх болов уу гэсэн таамаг ч явна. Монголын эдийн засагт Тавантолгойн таатай цаг үе хэзээ тохиох бол. ■

ДЭД БҮТЭЦ


# ХӨГЖИЛД ХҮРГЭХ ШИНЭ ЗАМ

Х.ХУЛАН

Дэлхийн банкнаас гаргадаг “Логистикийн Дүгцэтгэлийн индекс”-ийн үнэлгээнд Монгол Улс нийт оролцсон 150 орноос 140 дэх байрт жагсжээ. Эл тоо манай улс дотоод бүтцийнхээ чанарыг сайжруулж, логистикоо чадавхижуулах шаардлагатайг дурайтал харуулж байна.

Дэлхийд далайд гарцгүй 43 орон байдгийн нэг нь талын Монгол. Иймд манай улсын хувьд төмөр замын сүлжээгээ өргөжүүлэн хөгжүүлэх

нь эдийн засагт онцгой ач холбогдолтойг хүн бүр хүлээн зөвшөөрөх буй за. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сард Засгийн газраас шинэ төмөр зам бүтээн байгуулах ажлын тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид олгосон. Ингэснээр Оюутолгой, Тавантолгой ордоос олборлох байгалийн баялгийг зах зээлд нийлүүлэх хамгийн оновчтой логистик хийгдэх учиртай. ▶



Эх сурвалж: Зам, тээврийн яам



▶ “Шинэ төмөр зам”-ын нэг болон хоёрдугаар шатанд Тавантолгой- Сайншанд- Баруун- Урт-Хөөт- Чойбалсан- Хөөт- Нөмрөг- Тавантолгой- Гашуун сухайт чиглэлд тавих нийт 1800 км төмөр замыг 2016 онд дуусгахаар төлөвлөжээ. Харин эхний ээлжинд барих Ухаа худаг- Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын суурь бүтцийн ажлыг энэ оны дөрөвдүгээр сард эхлүүлэхээр байгааг Зам, тээврийн яамны Төмөр замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Б.Артур хэлсэн.

## 5.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт

“Шинэ төмөр зам”-ын 1800 км төмөр замыг барихад 5.2 тэрбум ам.доллар шаардлагатай гэсэн тооцоо гарсан байна. Үүнд, санхүүжилтийн 51 хувийг Монгол Улсын Засгийн газраас, үлдсэн 49 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдаас босгохоор зэхжээ. Түүнчлэн, тусгай зөвшөөрөл, концессын эрх, зурвас газар гэхчлэн биет бус хөрөнгө оруулалтад нэмж Чингис бондын хөрөнгөөс 400 сая ам.доллар гаргаж, төрийн өмч давамгайлсан байдлаар хэрэгжүүлэх гэж байна. Өнөөгийн байдлаар суурь бүтцийг барихад хөрөнгө оруулах сонирхолтой гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг урьсан тендерийн урилгыг “Financial Times” болон өдөр тутмын сониноор зарласан. Энэхүү урилгын дагуу гаднын 20 гаруй компани саналаа ирүүлсэн байна. Сонгон шалгаруулах ажил хараахан дуусаагүй тул компаниудын нэрсийг зарлах болоогүй гэж “Монголын төмөр зам” компаниас мэдэгдсэн билээ. “Шинэ төмөр зам” төслийн ТЭЗҮ-г “МакКинсей энд компани”-аас боловсруулсан бөгөөд уг тооцооллын дагуу 9.4 жилийн хугацаанд зарлагаа нөхөх боломжтой гэнэ.

## Улстөржилтийн дараах шийдвэр

Монголчууд биднийг төмөр замын царигаа өргөнөөр тавих уу, нарийнаар уу гэдэг асуудлаа улстөржүүлж байх хооронд дэлхийн ертөнц хурдацтай хөгжиж байна. Жишээлбэл, өнгөрсөн оны есдүгээр сард Казахстанд хэлэлцсэн “Казахстан-Шинэ торгоны зам-Ази Европыг холбох гүүр” дугуй ширээний ярилцлагаар хэлэлцсэн “Цахилгаан галт тэрэг” төслийг PPP буюу төр, хувийн хэвшлийн зарчмаар хэрэгжүүлэх гэж байна.

Харин ихээхэн маргаан дэгдэж, улстөржсөн энэхүү асуудлыг Засгийн газар дараах байдлаар эцэслэн шийджээ. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын дөрөвдүгээр бүлэгт “Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын хөгжлийг хангах үүднээс Монгол Улсад шинээр барих төмөр зам нь одоо ашиглаж байгаа төмөр замын шугамтай шууд холбогдох буюу огтолцох нөхцөлд түүний царигийн өргөн нь 1520 мм” гэж заасан байдаг. Энэхүү бодлогын баримт бичигт тусгасны дагуу “Шинэ төмөр зам” төслийн суурь бүтцийг өргөн царигаар барих болжээ. Өөрөөр хэлбэл, өргөн царигтай замаар тээвэрлэж буй нүүрсээ шилжүүлэн ачина. Монгол Улс төмөр замын сүлжээгээ өргөтгөснөөр баялгаа машинаар зөөж байгаль экологийн сүйрэл даллах биш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж, далайн зах зээлд ойртох боломжтой болно.

Юутай ч асуудал цэгцэрч, бүтээн байгуулалтын ажил эхлэх нь. Гэхдээ төмөр зам дагасан бүтээн байгуулалт бий болгоход төрөөс ихээхэн хөрөнгө, холч ухаан, оновчтой бодлого хэрэгтэй нь дамжиггүй. ■

ГАРЦ

# “ГОЛЛАНД ӨВЧИН”-ИЙГ АНАГААГЧ



## Б.ЭНХЦЭЦЭГ

“Голланд өвчин”-ийг “Голланд гайхамшиг” болгож чадсан тус улсын Ерөнхий сайд асан Вим Кок энэ жил Монголын эдийн засгийн чуулганд урилгаар хүрэлцэн ирж илтгэл тавьсан билээ. Түүний хэрэгжүүлсэн “Polder model” хэмээх загварчлал Голланд улсад 10 гаруй жил үргэлжилсэн уул уурхайн орлогод хэт дулдуйдаж бусад салбараа шахах үзэгдлийг “номхотгож” чадсан байдаг. Энэ үед АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтон хүртэл баяр хүргэж “Вим, Та анхных нь байсан шүү” хэмээн хэлж байсан удаатай. Монголын эдийн засгийн чуулганы үеэр тэрбээр “Mongolian Economy” сэтгүүлийг онцлон ярилцлага өгсөн юм.

## –“Голланд өвчин” үүсэх болсон шалтгааны талаар ярилцлагаа эхлэх үү?

–Байгалийн баялгийн орлогодоо хэт хөтлөгдөж, өндөр хөгжсөн аж үйлдвэрлэлийн салбараа ганхахад хүргэснээс үүдэлтэй. Байгалийн хийн олборлолт, нөөцөөс орж ирж буй нэмэлт орлогыг боловсрол тэргүүтэй өндөр үр ашигтай салбарт хөрөнгө оруулалт болгож хангалттай зараагүй. Тухайн үеийн төсвийн зарцуулалтад нэлээд ашигласан. 40 жилийн өмнө Нидерланд төдийгүй Европ тэр аяараа эдийн засгийн хямралд бүдчиж байсан үе юм. Үүнээс үүдэн бид үнийн өсөлт, өндөр инфляци, ▶

Фотог Э.Зоригт

► төсвийн алдагдал руу халтирсан.

Голланд өвчнийг давахын тулд шинэ шийдэл олох хэрэг гарсан юм. Эцэст нь, Голланд өвчин амжилтын түүх болон хувирч, бид өдийг хүртэл Евро бүсийн хүчирхэг эдийн засагтай орнуудын нэг хэвээр байна. Үүгээр бид өвчин тусах нь ноцтой асуудал боловч түүнээс ангижирч болно гэдгийг харуулсан. Гэвч нэн тэргүүнд ашигт малтмалын орлогоо дэд бүтэц, боловсрол гэсэн бүтээмж өндөртэй салбарт зарцуулж, түүнээс сэргийлэх нь зүйтэй. Ашигт малтмалын үйл ажиллагаанаас орж ирж буй нэмэлт орлогоор хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж болдог.

**-Нидерланд улсын өндөр хөгжсөн аж үйлдвэрлэлийн салбар байгалийн баялгийн нээлт, олборлолтоос үүдэн шахагдаж, уналтад орсон гэдэг. Голланд өвчний өмнө болон дараа аж үйлдвэрийн салбарын байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ?**

-Аж үйлдвэрийн салбар үргэлж л хүчирхэг байсан. Яагаад гэж үү. Учир нь бидэнд байгалийн хийгээс өөр баялаг байгаагүй. Мөн олон улсын худалдаа, экспорт, импортоос дэндүү хамааралтай улс. Экспорт манай улсын ДНБ-ий 50 хувийг эзэлж байна. Тиймээс бид хүчирхэг аж үйлдвэрийн суурь салбараар өрсөлдөх чадвараа хадгалах хэрэг гардаг. Гэвч тэр үед Голланд өвчинд нэрвэгдэж, манай улсын эдийн засаг тэр дундаа үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа уруудаж эхэлсэн юм. Тодорхой тооны компани цаашлаад бөс бараа, усан онгоцны үйлдвэрүүд хүртэл хаагдахад хүрч, олон хүн ажилгүй болж эхэлсэн. Аж үйлдвэрийн салбар сэргэхэд удаан хугацаа шаардсан. Гэсэн ч уг салбар өнөөдөр дахин цэцэглэн хөгжиж байна. Манай улсын хувьд хүн амын насжилт, бусад улсын дэлхийн зах зээл дэх өрсөлдөх чадварын өсөлт гэхчлэн амаргүй асуудал олон байгаа ч аж үйлдвэрлэлийн салбарын хөгжил өндөр түвшинд явж байна.

Юу хэрэгтэй вэ гэвэл, өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, чадвартай боловсон хүчин. Боловсролын чанар онцгой сайн байх нь олон улсад өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн өндөр үр чадвартай иргэдтэй болж чадна гэсэн үг.

**-Нидерланд евро бүсийн хямралаас хэрхэн зайлсхийж байна вэ?**

-Уг хямралд бүгд өртөж байна. Одоо ч Европ шигүү ой дундаас хараахан гараагүй. Гэвч евро бүсийн “цаг агаар” хагас жилийн өмнөхөөсөө өнөөдөр харьцангуй дээрдчихээд байна. Хүн бүр энэ үйл явцыг гутранги өнгөөр харж байв. Харин сэргэж буй энэхүү өөдрөг төсөөлөл биднийг хямралаас авч гарах гарц болно.

Нидерланд Скандинавын орнууд болон Германтай мөр зэрэгцэж, өдийг хүртэл гурван А (AAA) зээлжих зэрэглэлтэй цөөхөн орнуудын нэг байсаар ирлээ. Тогтвортой байдал, санхүүгийн эрүүл мэндийн хувьд Нидерландын нэр хүнд өндөрт

яваа. Энэ бол сайн мэдээ.

“Polder model” хэмээх загварчлалын үрээр бид энэ бүгдийг бүтээсэн. Улсынхаа төлөө нэгдэж, нэг зорилгын төлөө бие биенийгээ сонсож чаддаг ТББ, холбоод, ажил олгогчид, нийгмийн зүтгэлтнүүд байсан учраас тэнд хүрч чадсан. Энэ бол Нидерланд улсын хувьд төдийгүй Монголын хувьд маш чухал гэдгийг хэлье. Төр, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэл, төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагуудыг огтлолцуулж байдаг нийтлэг эрх ашгийн нэг талбартай байх нь маш чухал юм шүү. Тэд үргэлж санал нэгдэж байх албагүй. Зарим үед зөрчилдөж, биенээ сонсч, ятгаж, нэн тэргүүнд тавигдах нийтлэг зорилтуудаа тодорхойлох нь улс бүрийн хувьд туйлын чухал.

**-“Polder model” загварчлал Нидерланд улсын бодлогын нэг хэсэг одоо ч байсаар байгаа юу. Эсвэл үеэ өнгөрөөсөн стратеги уу?**

-Хуучин загварчлал гэдэг экспортын бүтээгдэхүүнтэй адилгүй гэдэг нь мэдээж. Солонгос, Монголд авчирч болно. Гэхдээ тухайн улс орны нөхцөл байдалд тохируулан хөгжүүлэх хэрэгтэй. Одоо үе болон ирээдүйн нөхцөлд тохирохгүй хуучирсан гэдэгтэй санал нэгддэггүй. Нийтлэг эрх ашигт тулгуурласан чиг хандлага, нийгмийн харилцаа бүх улс орны ирээдүйн хувьд маш чухал гэж боддог. Хэрхэн хийх нь тэдний л хэрэг. Хүн бүр өөр, өөрсдийн арга барилаар асуудалд хандаж шийдвэрлэж болно. Гэхдээ бидний загварчлалыг харахад гэмгүй л гэж боддог.

Жишээ татъя. Уул уурхайн салбараас та нарт орлого орж ирж буй. Бид үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдээ хэрхэн тодорхойлж, эдийн засгаа төрөлжүүлэх талаар ярьдаг. Одоогоос таван жилийн дараа бид хаана хүчирхэг байх вэ. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд юуг хийх ёстой вэ гэх зэрэг. Нийгэмд хүн бүрийн оролцоог татаж чадах нь нэн чухал. Гэвч үүнийг зөвхөн Засгийн газар, хувийн хэвшлийнхний гар гэж ойлгож болохгүй. Энэ бол Засгийн газар, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагууд юм. Хүн бүрт тус дэм болох оролцоо гэж бий. Тиймээс нийтлэг зорилтуудаа тодорхойлдог. Хүн бүр нэг зүгт харцаа чиглүүлнэ гэдэг суурь бат байна гэсэн үг. Энэ л хамгийн том тус.

**-Зарим мэргэжилтэн болоод олон улсын байгууллага Монгол Улсыг аль хэдийнэ Голланд өвчинд нэрвэгдчихсэн гэж дүгнэж буй. Ийм нөхцөлд тулаад ирчихсэн орны хувьд дараагийн авах алхам юу байх вэ. Мөн ямар замаар эдийн засгаа төрөлжүүлж болох вэ?**

-Нэн тэргүүнд уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас оржирж буй нэмэлт орлогыг үрдүнтэй хөрөнгө оруулалтад зарцуулах хэрэгтэй. Өнгөрсөн хугацаанд баталчихсан олон хууль, төсвийн дүрэм журмууд байна. Тэднээс хазайлгүй, чанд дагаж мөрд. Бүх төсөл нэг түвшний ач холбогдолтой ►

► бишээс хойш тэргүүлэх чиглэлүүдээ юу вэ гэдгийг сайн бодох хэрэгтэй. Хамгийн түрүүнд тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлох ёстой. Боловсрол мэдлэг, инноваци, судалгаа шинжилгээ хамгийн чухал нь гэж би хувьдаа хэлнэ. Битгий мартаарай. Дан ганц зам, барилга, төмөр замын бүтээн байгуулалтыг бодохын оронд хүмүүсээ яаж чадавхжуулж, шинэ түвшинд гаргах вэ гэдгийг бод. Учир нь, Монгол шиг орны хувьд өндөр чадавхитай боловсон хүчинтэй байж гэмээнэ удаан хугацаанд олон улсын тавцанд өрсөлдөж чадна.

Мөн хөрөнгө оруулалтын орчин, түүнийг гаднын хөрөнгө оруулагчид урьдчилж таамаглаж болохуйц байхад анхаарах хэрэгтэй. Тийм байж чадваас тэд энэ улсад ирэхдээ мөнгө, санхүүгийн орчин ямар болох, гэнэтийн бэлгээр гайхшруулах эсэхийг эргэлзэхгүйлгүй мэднэ. Тодорхой байдалгэдэг асар чухал агаад бизнес эрхлэлтийг дэмждэг гол хүчин зүйл. Жижиг, дунд үйлдвэрлэлийн аз сорьсон үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих нь мөн зүйтэй. Тэдгээр компаниудын үйл ажиллагаа явуулах боломжийг хангаж, санхүүгийн байгууллагуудаар зээл олгуулах зэргээр санхүүгийн системээр нь зохицуулалт хийж өгөх хэрэгтэй. Үйлдвэрлэл, санхүүгийн салбар хоёр хамтдаа байсан тохиолдолд хөл дээрээ зэрэг босдог учир нэг нь ганцаараа өөдөлнө гэж байхгүй. Санаа оноогоо уралдуулан нэгтгээд эдийн засгаа хүчирхэг болгоход ашигла.

Төрөлжилтийн хувьд одоогоор аль хэдийнэ бүрдчихсэн байгаа хүчин чадлаа л ашиглах нь зүйтэй. Монголын эдийн засгийн хувьд мэргэжилтэн шиг мэдлэггүй ч олон янзын үйл ажиллагааны цуглуулга, экспортын дэмжлэг ихээхэн тус болно гэж бодож байна. Шууд бүтчихдэг зүйл биш л дээ. Хугацаа хэрэгтэй. Нидерландчууд бид ч цэцэгсээ ургуулж, олон улсад түүнийгээ таниулахын тулд урт удаан хугацаанд хөдөлмөрлөсөн. Монголын тодорхой салбаруудын тухайд ч ийм л замналыг туулна.

**-Монгол тэргүүтэй байгалийн баялаг ихтэй орнууд сангийн бодлогодоо ямар тэргүүлэх зарчмуудыг баримтлах нь зүйтэй вэ?**

-Төсөв сангийн хуучинсаг (консерватив) үзэл баримтлалд тулгуурлах гэж хэлнэ. Энэ нь байхгүйгээ үрэхгүй гэсэн үг. Орлогын энгийн эх үүсвэрт суурилан юунд зарцуулах вэ гэдэгт маш нарийн хандах хэрэгтэй. Мөнгөө зүгээр нэг гарынхаа салаагаар урсгачихаж болохгүй. Яагаад хэрэгтэй юм, ямар үр дүнг үзэх юм гэдэг нарийн тодорхойлолтгүйгээр

төсөл битгий сонго.

**-Аль хэдийнэ Голланд өвчинд нэрвэгдчихсэн Монгол Улс хэрхэн илааршиж болох вэ?**

-Монгол Улс зөв зам дээр зогсож байна. Ядуурлын түвшин дээгүүр, орлогын хэмжээ доогуур ч хөгжингүй орон болох шатаар алхаж байна. Гэвч тус өсөлтийг нийтэд хүртээмжтэй байлгах тал дээр маш их ажил хийх хэрэгтэй.

Монгол өндөр инфляцийн эрсдэлийг маш сайн тооцоолж, түүнээс болгоомжлох нь зүйтэй. Танай улсын Төвбанкны Ерөнхийлөгч инфляци буурч байгаа гэж хэлсэн. Хэдийгээр инфляци доошилж байгаа ч өндөр түвшинд байсаар байна. Энэ бол мэдээж асуудал. Замаасаа хазайчихгүй урагшлах арга бол удаан хугацаанд нийт иргэнд болоод эдийн засагт өгөөжтэй тэргүүлэх ач холбогдолтой эх үүсвэрүүдэд хөрөнгө оруулах юм.

**-Аливаа улс орны халамжийн бодлого ямар байвал хамгийн зохист хувилбарт тооцогддог вэ?**

-Энэ бол ард иргэдийн хүслээс л шалтгаална. Азийн орнуудад хуучнаа бодвол илүүтэйгээр хөгжил, хөрөнгийг халамжийн системтэй холбох хандлага ажиглагдах болж. Тухайлбал, Хятад, Солонгост өрнөж буй мэтгэлцээнээс харж болох. Гэвч халамж гэдэг үнэгүй олддог зүйл биш гэдгийг санах ёстой. Хэн нэгэн түүнийг төлөх л ёстой. Халамжийн бодлогыг тэд л авч яваа. Тухайлбал, ажлаа алдсан нэгэнд ажилгүйдлийн тэтгэмж ямар чухлыг ойлгоно гэдэг орлогынхоо тодорхой хувийг цааш нь хийнэ гэсэн үг. Ийм л учраас нийгмийн даатгал, бусад татвараас халамжийн мөнгийг бүрдүүлж байдаг. Энэ бол диваажингаас буугаад ирдэг үнэгүй бэлэг биш.

Халамжийн системийг мэдээж хүлээн зөвшөөрдөг. Европ болон манай улсын бий болгож чадсан халамжийн системээр би их бахархдаг. Гэвч та бүхэн энэ мөнгө бусдын хөлс, хүч гэдгийг ямагт санах нь зүйтэй. Тодорхой зорилгоор хадгалж буй энэ мөнгийг зүгээр нэг цалин хөлс нэмэгдүүлэхэд ашиглаж огт болохгүй.

**-Халамжийн хэт тэлсэн бодлого Монгол Улсыг хааш нь аваачих бол ?**

-Монгол Улсын халамжийн бодлого тэгж их тэлээд байна гэж бодохгүй байна. Халамжийн бодлогыг хазаарлаж, зөв зүгт залах гэж хичээж буй одоогийн оролдлогыг “халамж бол бэлэг биш” гэдгийг ойлгож буйн үр дүн гэж харж байна. Халамжийн бодлогын одоогийн харагдаж буй дүр зургийг цаашид хөгжүүлэх нь тийм өндөр эрсдэлтэй алхам гэж бодохгүй байна. ►



► -Уул уурхайн салбарын бүтээгдэхүүнүүдтэй эн зэрэгцэх бусад төрлийн брэнд бүтээгдэхүүн гаргаж ирэхийг зорьж буй монголчуудад Та юу гэж зөвлөх вэ?

-Гаднын хүний нүдээр харахад ашигт малтмалын бүтээгдэхүүнээ зөвхөн түүхийгээр нь экспортлоод байхын оронд үйлдвэрлэлд татах хэрэгтэй л гэж хэлмээр байна. Хөдөө аж ахуйн салбарыг тухайлбал, түүнээс гаргаж авч болох бүтээгдэхүүнтэй нь сайн холбож өгч болно. Тухайлбал, Нидерландад улсынхаа хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийг өсгөөд зогсохгүй эдийн засгийн өсөлтөд голлох байр суурь эзлэх хэмжээнд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг чадварлаг компаниуд байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн үгэндээ төрийн албаныхны хандлага, ёс зүйг чухалчилж байсан. Дүрэм, журам түүний хэрэгжилтэд зөвхөн сэтгэл ханаж болохгүй. Энэ бол их чухал.

**-Монгол Улс ногоон эдийн засгийг**

**хөгжүүлэхийг зорьж байна. Урт хугацаанд ногоон гэдэг тодотгол эдийн засагт хэр өгөөжтэй байх вэ?**

-Бидний хэн хэн нь байгаль орчны тогтвортой байдалд онцгой анхаарал тавих хэрэгтэй. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үндэстэн дамнасан хувийн компаниуд нэн ялангуяа үүнийг маш сайн анхаарах нь зүйн хэрэг. Эцэстээ энэ бол тухайн компанийн зөвшөөрөл урт хугацаанд үйл ажиллагаа явуулж чадах эсэхтэй холбоотой асуудал. Хүрээлэн буй орчин, агаарын чанарыг муутгах нь компаниудад ч ашиггүй. Төр, хувийн хэвшлийнхний зүгээс уул уурхайг илүү хариуцлагатай, байгаль орчны хувьд тогтвортой байлгахад хамтарч ажиллах ёстой. Олон улсын гэрээ хэлэлцээрт тулгуурлан стандарт тогтоож өгөх нь нэн чухал. Ашигт малтмалын орлого чухал ч илүү тогтвортой, байгаль орчинд ээлтэй замаар уул уурхайн үйл ажиллагаа өрнөх ёстой. Алс хэтдээ энэ л бидэнд хамгийн ашигтай хэлбэр юм. ■



Хөдөлмөрийн намын дарга "Вим" Кок  
1987.04.04 (49 настайдаа)

## Бидний алдааг битгий давтаарай

Энэ жилийн Монголын эдийн засгийн чуулганы хүндэт зочдын нэг нь Голландын Ерөнхий сайд асан Вим Кок байсан билээ. Тэрбээр Нидерланд улсын Сангийн сайд түүний дараагаар Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэсэн бөгөөд нийт 13 төрийн жил алба хаажээ. Вим Кок нь чуулганы үеэр Голланд өвчнийг хэрхэн Голланд гайхамшиг болгож чадсан тухайгаа хуваалцахын зэрэгцээ Монгол Улс "үхэлд хүргэх" уг өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар зөвлөмж өгсөн юм. Уншигч та бүхэнд уг илтгэлийг орчуулан хүргэж байна.

Монгол Улс эдийн засгийн гайхам шинэ давлагаа руу орох гэж байна. Ирэх таван жилд хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэх эдийн засгийн хүчтэй өсөлтийн гол нуруу нь байгалийн баялаг байхаар байна. Эдийн засагт эзлэх нийт уул уурхайн хэмжээ болон ДНБ-ий хэмжээ өмнөх арван жилтэй харьцуулахад хоёр дахин өсч, 20 хувь болох төлөв бий. Эргэлзээгүй энэ нь

ойрын ирээдүйд ажил эрхлэлт болон хүн амын амьжиргаа дээшилнэ гэдгийг хэлээд байна. Гэвч түүнтэй зэрэгцэн байгалийн асар их баялгаас үүдэлтэй эдийн засгийн огцом өсөлт нь үл тоомсорлож боломгүй өндөр эрсдэл дагуулдагийг онцлон хэлье. Ашигт малтмалын арвин нөөцтэй дэлхийн бусад улсыг тойролгүй дайрч өнгөрсөн эрсдэлүүдтэй монголчууд ч тулгараад байна. Гадаадын хөрөнгө оруулалт, валютын урсгал нь валютын ханш, бараа үйлчилгээ, инфляци, цалин хөлсний хувьд зайлшгүй өсөлтийн давалгааг үүсгэнэ. Нөгөө талаас амьдралын өртөг нэмэгдэж, экспорт, импортын компаниудын өрсөлдөх чадвар суларч хүнд байдалд орж эхэлдэг. Бусад улсын туршлага аливаа орон хэчнээн хүчирхэг байгууллагуудтай байсан ч байгалийн баялгаа олборлоод ирэхээр тэдгээр компаниуд "Голланд өвчинд" нэрвэгдэх менежментийн эрсдэлүүдтэй тулгардагийг харуулж байна

Манай улс 1960 оны эхэн үед ▶

► байгалийн хийн баялгийн нээлт нь Нидерландад юу авчирсныг хувийн туршлагаасаа хуваалцах нь зүйтэй болов уу. 1973 болон 1979 онд газрын тосны нийлүүлэлт зогсож, үнийн “шок” үүсэх үеэр Голланд халамжийн мөнгө ихээр тарааж, цалингийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр амьдралын өртөг ч өсч эхэлсэн. Улмаар энэ нь экспортын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын өрсөлдөх чадвар суларч, ашиг орлого багасахад нөлөөлсөн юм. Аж үйлдвэрлэлийн салбарын жилийн дундаж өсөлт 1970 оны эхний хагасаас хоёрдугаар хагаст шилжих үест 4.2 хувиас 0.7 хувь болтлоо буурсан. Түүнчлэн тус салбарын нийт хөрөнгийн хэмжээнд эзлэх орлого 1970 онд 17 хувь байсан бол түүнээс хойш арван жилийн дараа зургаан хувь болж багассан байгаа.

Энэ бүхэн манай улсын байгалийн хийн нээлт, олборлолтоос үүдэлтэй гэж буруугаар битгий ойлгоорой. Тэр үед дэлхийн бусад улс хэцүү үеийг туулж байсан. 1970 оны сүүл гэхэд бид бүгд дэлхийн эдийн засгийн хахир хатуу хямралыг амсаж байсан. Гэсэн ч нийгмийн халамжийн мөнгөөр дамжуулан төсвийн зарцуулалтыг өсгөсөөр байв. Байгалийн баялгийн орлого нэмэгдэх тусам халамжийн мөнгө өсөх хүлээлт байсан. Энэ нь ч чадлаасаа давсан их мөнгө зарцуулах шаардлага гарсан нөхцөл байдлын эсрэг зогсох ямар хэцүү байдгийг Голландын Засгийн газарт амсуулсан билээ.

Төрийн зардал 1970-аас 1982 оны хооронд ДНБ-ий 45 хувиас 66 хувь болтлоо өсч, төсвийн алдагдал огцом цойлсон. Засгийн газар тэр үеийн болон ирээдүйд орж ирэх байгалийн хийн орлогоо тооцоолон, зарлагаа нэмэгдүүлсээр байсан юм. Улмаар богино хугацаанд, инфляцийн өсөлт, цалингийн нэмэгдэл хоёр хавсарч, дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг илт муутгаж, төсвийн алдагдал асар хурдацтай ихэссэн билээ. Үүнийг л Голланд өвчин гээд байгаа юм.

Манай улсын олон үйлдвэр давжаарч эс бөгөөс хаалга барихад хүрсэн. Нийт ажилгүйдлийн түвшин тэр дундаа ажилгүй залуусын тоо огцом нэмэгдсэн юм. Уруугаа чиглэсэн уг хандлагыг зөвхөн урьд нь хэрэглэж байгаагүй шинэ санаачилга л зогсоож чадахаар байв. Энэ хэсгээс хойш миний түүх эхэлсэн

гэж хэлж болно.

Тэр үед буюу 1980 оны эхэнд би Нидерландын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга байсан юм. Тиймээс ч ажил эрхлэгч болоод тэдний гэр бүлийн эрх ашгийг хамгаалах нь миний тэргүүн үүрэг байв. Тухайн үед тэдний дийлэнх нь ажлаа алдахад хүрсэн эсвэл аль хэдийнэ ажилгүй болчихсон байсан. Цаашлаад манай улсын халамжийн системийн тогтвортой байдал ганхаж, аюулд орсон гэсэн үг.

Олон арван жил ноёрхож буй улсынхаа нийгэм хамгааллын тогтолцоо, халамжийн системээр би их бахархдаг. Ямартай ч тус систем нь Швед, Дани, Норвеги, Финлянд, Герман зэрэг улсад их бага хэмжээгээр нөлөөлөөд явж байна. Тус хямралын үед зогсонги эсвэл хасах чиглэлд явж буй эдийн засаг ямар ч боловсронгуй нийгмийн халамжийн системтэй байлаа гэсэн түүнийгээ эрсдэлд оруулдаг гэдэг нь маш тодорхой болсон. Далайн түрлэгийг эргүүлэхийн тулд Засгийн газар хуулиар цалингийн хоригийг ногдуулсан юм. Хуулийн дагуу энэхүү арга хэмжээг эсэргүүцэж хүчтэй бослого хөдөлгөөнийг хөдөлмөрийн холбоод зохион байгуулж байлаа. Гэсэн ч ямар ч үр дүнд хүрээгүй л дээ. Харин хариуд нь нийгмээрээ догширч, таагүй уур амьсгал зонхилох болсон юм. Гарц гэдэг нь ч хүрэхэд асар хол санагдаж байсан үе. Засгийн газар 1982 оны эцсээр цалин хөлс, нийгмийн халамжийн хэмжээг царцааж, хөдөлгөөнгүй барих бодлогоо үргэлжлүүлэхийн тулд дараагийн шатны хуулийн арга хэмжээгээ зарласан юм. Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгчийн хувьд би Ажил олгогчдын холбоотой шууд хэлэлцээр хийхийг санал болгосон. Нэг талаас цалингийн барих бодлогыг үргэлжлүүлэхэд сайн дураараа хүлээцтэй хандаж, нөгөө талаас ажлын цагийг багасгаж, залуус болон ажилгүй иргэдийг ажиллуулах, тэдэнд боломж өгөх урт хугацааны тохиролцоог хоёр талаас хийхийг хүссэн юм. Тус гэрээний тохиролцоонууд нь үйлдвэрчний эвлэл болон ажилчдын хувьд сайшааж хүлээж авахаар дөхөм байгаагүй. Богино хугацаанд өндөр үнэ төлж, худалдан авах чадвараа алдах ч хариуд нь урт хугацааны өндөр үр ашиг, ажилгүй иргэд ажилтай болохоор байсан юм. Тэр үед бидэнд хувьд итгэж, эерэг үр дүн хүлээхээс өөр арга байгаагүй. Ард иргэд намайг яагаад ►

► дэмжсэн бэ гэвэл эдийн засаг болон нийгмийн нөхцөл байдал өдөр ирэх тусам дордож байсан учир юу ч хийхгүй байх нь сонголт биш байсан.

Олон жилийн дараа гэрээ аажмаар үр дүнгээ өгч байгаа нь хүмүүст тодорхой мэдрэгдэж эхэлсэн. Ажлын байр нэмэгдэж, бодит орлого өсөхийн хажуугаар өртөг өндөртэй ч гаднын хүчин зүйлд өртөмтгий бус нийгмийн байгууллага хадгалсаар байсан юм. Нийгэмд амгалан тайван байдал тогтож, ажилчид илүү урам зориг дүүрэн урагшилж эхэлснээр компаниудын ашиг орлого нэмэгдэж, өрсөлдөх чадвар өсөх болсон юм. Хэдийгээр 1990-иэд оны дунд үе хүртэл энэ үйл явц үргэлжилсэн ч эцэст нь манай улсын эдийн засаг бүхэлдээ Голланд өвчнөөс илааршиж, Европ амжилт “Polder model” хэмээн алдаршсан юм. Энэ загвар нь төсөв сангийн консерватив үзэл баримтлал дээр суурилан валют болон цалингийн хязгаарлалтыг зохицуулж, шаардлагатай нэгнийг өндөр түвшний нийгмийн хамгаалалд багтаахын зэрэгцээ хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэлийг хийж чадсан үйл явц юм.

Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байсан эхэн үе буюу 1995 онд манай улс “Flex security” хэмээх хувьсгалын шинжтэй бодлогыг хөдөлмөрийн зах зээлдээ танилцуулж, нийгмийн аюулгүй байдал, уян хатан чанарыг тэнцүүлэхийг зорьсон юм. Хөдөлмөрийн зах зээлийн оролцоо, ажил эрхлэлтийн түвшний хувьд Европын тэргүүлэх орнуудын нэг болоход энэ л хамгийн их хувь нэмэр оруулсан. Гэвч ажил олгогч, хөдөлмөр эрхлэгч гэсэн үйлдвэрлэлийн салбарын тулгуур талуудын идэвхтэй оролцоо байгаа нөхцөлд л дээрх амжилт боломжтой гэдгийг дахин хэлье.

Миний хувьд Нидерландын энэхүү түүх нь Монголтой зарим талаараа холбоотой санагдаж байна. Нэн тэргүүнд танай улсын хувьд Нидерланд гэгч улсын хэдэн арван жилийн өмнө амссан өвчнөөс зайлсхийх нь хэчнээн чухал болохыг манай улсын түүх гэрчлэн харуулж байна. Эдийн засаг тань уул уурхайгаас дэндүү их хамааралтай. Орлогынхоо дийлэнх хувийг үр ашиг багатай чиглэлд зарцуулсан Нидерландын алдааг битгий давтаарай гэж чин сэтгэлээсээ зөвлөж байна.

Хэрвээ би зөв ойлгосон бол, танай улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гурван чухал зүйлийг тусгасан юм

билээ. Өр, зарлага, төсвийн алдагдлыг тодорхой хэмжээнд зааж өгсөн дээд хэмжээ, хязгаарлалт. Дээрх гурав нь Голланд өвчинд нэрвэгдэх эрсдэлийг хязгаарлах хүчтэй. Монгол Улсыг өвчлөхөөс сэргийлэх энэ санаачлагыг гаргасан тэдгээр хүнд тусгайлан баяр хүргэмээр байна.

Гэвч өрсөлдөх чадвар бүхий, төрөлжсөн хүчирхэг эдийн засгийн суурийг бий болгохын тулд ихийг хийх хэрэгтэй нь мэдээж. Монголчуудад сайхан амьдрах өнөөдөр, маргаашийн боломжийг нээж өгөх гэж байгаа бол одоогийн эдийн засгийн шилжилт тань бүгдийг хамарсан эрх тэгш, тогтвортой байгаа эсэхэд хяналттай ажил.

Хоёрт, Өвчнийхөө хамгийн зовиуртай хэсгийг авч, ардаа орхиж чадсан Нидерланд улсын арга барил Монголд хамааралтай. Хоёр талын харилцан хүндлэл, хариуцлагаа хувааж үүрэх замаар байгууллагуудаа чадавхжуулахын чухлыг бидний түүх харуулдаг. Ард иргэдийнхээ сайн сайхан, улсынхаа ирээдүйн төлөө үүрэг хариуцлагаа хувааж үүр. Нидерландад бид Нацист Германы хоёрдугаар дайны дараа улсаа дахин сэргээн босгох шаардлага гарсан. Тэр үед гаргасан хамгийн чухал шийдвэрүүдийн нэг нь ажил олгогч, хөдөлмөр эрхлэгч хоёр нийтлэг ашиг сонирхолоо харилцан зөвшилцөх, шийдэх аргаа хэлэлцдэг нийгмийн байгууллагуудыг бий болгох байсан юм. Нийгэмд амар тайван уур амьсгал тогтоход тэдгээр байгууллагуудын хувь нэмэр нэн их. Боловсронгүй халамжийн тогтолцоо, ажил эрхлэлтийн өндөр түвшин бүхий эдийн засагтай орны хувьд эсэргүүцэл, жагсаал гэдэг энгийн үзэгдэл биш. Санал бодол олон тийшээ салаалсан үед нийгмийн хэлэлцүүлгүүд саналын зөрүүг багасгаж, эерэг талыг нь ойлгоход тусалдаг. Хамтран ажиллах хэлбэр нь нэг улсын төлөө гэсэн нийтлэг зорилгын төлөөх ухамсар, оролцоог бий болгож байдаг. Энэ бол “Хамтрал” гэж миний нэрлэдэг улс төрийн орчин үеийн хандлага юм.

ДНБ-ий өсөлт гэдэг зүгээр нэг тоо байхаас чухал гэдгийг санаж яв. Макро эдийн засгийн өсөлт гэдэг зүгээр гайхуулах тоо бус ард түмний аз жаргал, амьжиргаа хэрхэн өсч, хүмүүс үнэлж, хүсч буй зүйлдээ хүрч чадаж буй эсэхийг илтгэх чухал үзүүлэлт юм. Ийм л учраас эдийн засгийн өсөлтийг нийгмийн оролцоо, халамжийн бодлого, нийгэм хамгаалалтай хамтатгах нь амин чухал юм. ►►

► Дэлхий нийтээрээ илүү ихийг хийж, хичээх ёстой цаг үед орж байна. Оюун санааны шилжилт бидэнд хэрэгтэй. Үйлдвэрлэх, хэрэглэх, амьдрах шинэ хэв маягийг сонгох шийдлийн нэг хэсэг нь байгаль орчны тогтвортой байдал байх ёстой. Миний амьдралаараа сурсан чухал хичээлүүдийн нэг нь бүх хувьцаа эзэмшигчид нийтлэг эрх ашгийг хөндсөн нэг зорилгын төлөө бодож, хөдөлж чаддаг нийгэмтэй улс орон л хамгийн амжилттай, эв нэгдэлтэй байдгийг ойлгосон явдал юм. Энэ нь нийгэм болоод экологийн талын өргөн хүрээний оролцоог хамтын ажиллагааны нэг хэсэг болгох замаар шударга ашгийн хуваарлалт хийнэ гэсэн үг. Байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн оролцоо хоёул сайхан амьдралыг цогцлоох салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд. Эдийн засгийн өсөлт, нийгмийн уялдаа холбоо, орчны тогтвортой байдлын хоорондын тэнцвэрийг зөв олох, хадгалах гол хариуцлагыг Засгийн газар үүрэх учиртай. Энэ бол хэзээ ч амар байгаагүй бөгөөд хойшид ч тийм байхгүй.

Аливаа улсын Засгийн газрын хувьд мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийг байгуулна гэдэг тэргүүний үүрэг. Боловсрол, судалгаа, шинэ санаачилгын гурвалжин бол эдийн засгийг төрөлжүүлж, бүтээмжийг дээшлүүлэх улмаар иргэдээ сайхан амьдруулах түлхүүр юм. Дэлхийн түвшинд амжилт гаргах, олон улсад өрсөлдөх чадвартай иргэдтэй болох гарцыг нээхэд тэргүүн ач холбогдол өгч, хөрөнгө оруулах нь Засгийн газруудын хийх ёстой ажил. Улсаас компани, их сургууль, судалгааны байгууллагуудын хоорондох төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж болно. Боловсролын салбарт хуваарилсан төсөв мэдээж томоохон үүрэг гүйцэтгэх ч энэ бол зөвхөн мөнгөөр шийдэгддэг асуудал биш.

Засгийн газар мөнгө өгөхөөс илүү хийх хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхэд Засгийн газар хариуцлага хүлээх нь зүйн хэрэг. Энэ бол тааварлаж болохуйц, ил тод сангийн бодлого, чанга гэрээ түүнчлэн эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах ба авлигалын эсрэг сайн засаглал гэсэн үг. Энэ Монголд ч хамаатай. Танай улсын нөхцөл байдалд дэд бүтцийн сайн төслүүдэд хөрөнгө оруулах, үйлдвэрлэлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, сайн санхүүгийн

салбартай байх мөн уул уурхайн салбарыг зөв зохицуулсан хуультай байх шаардлагатай байна. Уул уурхайн салбарын хуулиндаа байгаль орчны болон хүмүүсийн ахуй амьдрал дахь нөлөөллийг сайн тусгаж өгөх нь зүйтэй. Ингэснээр монголчуудад уул уурхайн ашиг, нөлөөлөл ил тод болж ирэх юм.

Хэрэв засаглалын зүгээс зөв хуулийн орчинг бүрдүүлж чадвал хувийн хэвшлийнхэн улсынхаа хөгжлийг дэмжих гол хүч байж чадна. Эхний ээлжинд компаниуд гадаадын шууд хөрөнгө оруулалт болоод технологийг авчирдаг. Туршлагаас үзэхэд нээлттэй хаалга бүхий бодлоготой орнууд гадаадын хөрөнгө оруулалтыг илүү татахын зэрэгцээ компаниуд нь ч гадаад түншлэлээ амархан өргөжүүлж чаддаг.

Байгаль орчны тогтвортой байдлын тухайд Засгийн газар компаниудад хөнгөлөлт урамшуулал үзүүлж, өртөг багатай цэвэр технологиор үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Засгийн газар байгаль орчны стандарт тогтоож, хувийн хэвшлийнхнийг зөв зүгт залах гол хүч нь.

Монгол яг одоо зөв зам дээр байна. Харин одоо унтах нойроо хугаслан шургуу хөдөлмөрлэх цаг чинь ирлээ. Энэ бол хамгийн хэцүү үе. Боломжоос зурахын зэрэгцээ эрсдэлийг нь үнэлнэ гэдэг хамгийн чухал. Дэлхийн эдийн засаг болон хөрш гүрний эдийн засгийн болзошгүй удаашралаас үүдэлтэй эрсдэлүүдийг хэрхэн давахаа сайн тооцоол. Танай улсын эдийн засагт би гурван бодлогын хүчин зүйлд онцгой анхаарал тавихыг зөвлөж байна. Нэгт, Уул уурхайн салбараар удирдуулсан эдийн засгийн чадамжаа хэрхэн ил тод, тогтвортойгоор хөгжүүлж болох. Хоёрт, Эдийн засгийн өсөлтөө хэрхэн төрөлжсөн суурь салбаруудаар чадавхжуулж, хотын болон орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжих. Гуравт, үйлчилгээний салбар, боловсрол, эрүүл мэндийн салбарын хамрах хүртээмжийг хэрхэн дээшлүүлж, ядуурлыг багасгах вэ гэдэг юм. Монгол Улс дээрх гурван сорилтод маш шийдэмгий хандах хэрэгтэй. Байгалийн баялгаа нээж, ашиглана гэдэг улсын хувьд асар их хөрөнгө. Бусдын туршлагаас суралцана гэдэг болзошгүй эрсдэлээ хязгаарлаж, хишгийг нь иргэддээ эн тэнцүү хүртээх боломжийг бүрдүүлэх сонголт юм. Энэ бол сорилт.




Эдийн засагч

Л.БЯМБААГИЙН БУЛАН


# ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ХААНААС ЭХЛЭХ ВЭ

Монгол Улсын хөгжлийн чиг баримжааны талаар олон судалгаа, хэлэлцүүлэг хийж, олон бодлого хөтөлбөр боловсруулсан байдаг. Эдийн засаг сүүлийн жилүүдэд дэлхийн дундажтай харьцуулахад өсөлттэй байгаа нь чамлахааргүй амжилт хэдий ч манай улсын хөгжлийн гол парадокс нь ядуурал өндөр хэвээр байгаа явдал билээ. Энэ байдлаас хэд хэдэн асуулт урган гарч байгаа юм. Тухайлбал, эдийн засгийн өсөлт ард иргэдэд хүртээмжтэй байж чадаж байгаа эсэх, хөгжлийн загвар нь хэр удаан хадгалагдах боломжтой эсэх, мөн өөр илүү оновчтой шийдэл байж болох эсэх зэрэг асуултыг дурьдаж болох юм.

ДНБ-ийн өсөлт, хувь



Ядуурлын түвшин, хувь



## Эдийн засгийн хөгжил, хөгжлийн загвар юунаас эхэлдэг вэ?

Улс орны хөгжлийн загвар модель олон янз байдаг ч логик ухаанаар бодоод үзэхэд тухайн улсад юу байгаагаасаа буюу харьцангуй давуу талаасаа эхэлдэг болов уу. Жишээ нь, Сингапур газар нутаг, байгалийн нөөц баялаг үгүй тул дөрөөлж хөгжлийн хөтөч болгох хүчин зүйл нь гагцхүү тухайн улсын ард иргэд өөрсдөө, мөн газар зүйн байршил байсан юм. Иймээс Сингапур зөвхөн өөрийн ард иргэдийн оюун ухаанд тулгуурлан хөгжих хувь тавилантай байсан. 1994 онд анх Сингапурын Үндэсний хөгжлийн газар "Хязгааргүй Сингапур" үзэл баримтлалыг боловсруулан баталж байжээ. Энэхүү үзэл баримтлалд "...манай улс газар зүйн зааг хязгаарыг даван, дэлхийг тоглоомын талбар болгон сэтгэж чадах болно... Сингапур нь дэлхийн шинжлэх ухаан, технологийн төв; үйлдвэрлэл явуулах шилдэг байршил; дэлхийн худалдаа арилжаа, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээний зангилаа бүхий Ухаалаг арал болох юм." гэж тусгасан байдаг. Тэртээ 1994 онд яригдаж, төсөөлөгдөх төдий байсан зүйлс нь одоо сингапурчуудын бодит амьдрал болсон байдаг нь гайхалтай.

Үүний нэгэн адил жишээ Макао арал олон жил Португалийн колони орон байсан боловч одоо уугуул иргэд болох хагас сая хүн ам нь хангалуун амьдардаг. ДНБ-ий өсөлт өнгөрсөн онд 8,5 хувтай гарсан байна. Тус арлын хувьд Сингапуртай нэгэн адил газар нутаг, байгалийн нөөц баялаг үгүй, бас харьцангуй цөөн хүн амтай. Макао хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо газар зүйн байршил болон цаг агаарын тааламжтай байдлаа ашиглаж аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэхээр зорьсон байдаг.

Монголын тухайд сүүлийн хэдэн жилийн хөгжлийн хөтөч нь уул уурхайн салбар буюу байгалийн баялаг байлаа. Байгалийн баялаг нь ард түмний өмч гэж хуульчилсан хэдий ч байгалийн баялгаас үүдсэн эдийн засгийн үр ашиг иргэдэд шударга хуваарилагдахгүй, ядуурал улам гүнзгийрч хүн амын 1/3 нь ядуу болсон, эдийн засгийн бусад салбар сул дорой хэвээр, хойч үе нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгаас хүртэх боломжгүй гэх мэт хүндрэл тулгарч байна. Эдгээрээс улбаалаад ►

▶ манай улсын хөгжил урт удаан хугацаанд хадгалагдах боломжгүй, тогтворгүй, эмзэг болчихоод байгаа юм. Энэхүү нөхцөл байдлыг залруулахын тул гурван том шилжилтийг оновчтой байдлаар хийх хэрэгтэй мэт харагдаж байна.

### Үндсэн гурван том шилжилтийн механизм шаардагдаж байна

Эхний шилжилт нь уул уурхайн салбарын өсөлтийг эдийн засгийн бусад салбар луу гулгуулан шилжүүлж уул уурхайгаас хэт хараат байдлыг бууруулах явдлыг хэлнэ. Үүнийг эдийг засгийг солонгоруулах, төрөлжүүлэх ч гэж яриад байгаа.

Хоёрдахь шилжилт нь нөөц баялгийн ашиг шимээс цөөн тооны ард иргэд хүртэж байгааг задалж нийт ирд иргэдийг орлоготой, амьжиргааны түвшинг өндөр байлгахад чиглэсэн шилжилт. Энд тэгш хуваарилалт гэхээсээ илүү шударга хуваарилалтын зарчим үйлчлэх ёстой.

Гуравдахь шилжилт нь одоо үеэс ирээдүй хойч үе рүү залгамжлуулах, удаан хугацааны ул суурьтай тогвортой байдлыг хангахтай холбоотой. Өөрөөр хэлбэл, одоо олж байгаа орлогыг одоогийн ард иргэдэд зарцуулах бус хуримтлал үүсгэн, өсгөн арвижуулах замаар бидний үр садад өвлүүлэх шилжилтийг хэлнэ.

Дээрх гурван шилжилтийн тухайд шилжүүлж, дахин хуваарилах гэхээсээ илүү шударга, үр ашигтай, зах зээлд тулгуурласан механизмыг зөв тогтоож суулгаж өгөх нь бидэнд тулгарч буй хамгийн чухал асуудал болж байна.

### Төрийн оролдлого үр дүн муутай байна

Өнөөг хүртэл эдийн засгийн нөөц баялгийн дахин хуваарилалт, шилжүүлгийн үүргийг төр гүйцэтгэж ирсэн бөгөөд энэ явцад олон талаар бүтэлгүйтсэн байдаг. Үүний хамгийн энгийн жишээ нь Тавантолгой компанийн хувьцааны хуваарилалт юм. Байгалийн баялагаас иргэдэд хүртээх ёстой гэдэг санаа нь зөв боловч хэрэгжүүлсэн механизм буруу болсон. Компанийн өөрийн хөрөнгийг илэрхийлдэг санхүүгийн хэрэгсэл болох хувьцааг хуучны социализмын гэмээр тэгш хуваарилах аргыг хэрэглэн хүчээр тогтоосон үнээр бүх ард иргэдэд олгосон. Ингэснээр хэд хэдэн хүндрэлтэй үр дагавар гарч байгаа юм. Тухайлбал,

-Хувьцааны үнэ сонгодог зах зээлийн зарчмаар тогтоогүй, хийсвэр үнэ болсон

-Хувьцааг иргэдэд тараасан төр хувьцааны төлбөрөө тухайн компанид байршуулаагүй тул компанийн бизнес хөгжүүлэлтэд зарцуулах хөрөнгө байхгүй болсон, улмаар компани нь санхүүгийн хүндрэлд орсон

-Хувьцааны үнэлгээ анхнаасаа буруу тогтсон учир одоо хоёрдагч зах зээлд арилжаа явахад хүндрэлтэй, бодит санхүүгийн хэрэгсэл болж чадахгүй байна

-Дээрх байдлаас улбаалаад хувьцаа нь үнэгүйдэж, эдийн засгийн ач холбогдолгүй болсон

Өөрөөр хэлбэл, хэдийгээр иргэд Тавантолгойн хувьцааг эзэмшиж байгаа ч, тэр нь иргэдэд хүртээмжтэй бодит баялаг, хөрөнгө олж чадахгүй байна.

Тавантолгойтой адил хуваарилалтын механизм үр дүнгүй, үр ашиггүй хийгдэж байгаа жишээ цөөнгүй бий. Тухайлбал, тогтворжуулалтын, орон нутгийн хөгжлийн, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хүний хөгжлийн гэх мэт тусгай зориулалтын 40 орчим сан байдаг бөгөөд тэдгээрээр дамжуулан төр ДНБ-ий 30 орчим хувьтай тэнцүү хөрөнгийн дахин хуваарилалтыг хийдэг. Эдгээр

нь сан гэхээсээ илүү дахин хуваарилалт хийх данс хэлбэрээр л ажилладаг. Нийгмийн даатгалын тэтгэврийн нэрийн дансны хуримтлагдсан, хэзээ нэгэн цагт төлөх ёстой үлдэгдэл гэхэд л 5.6 их наяд төгрөгт хүрээд байгаа билээ.

### Өөр шийдэл байна уу?

Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд хувийн хэвшил Монголд цоо шинээр хөгжиж одоо ДНБ-ий 60-70 орчим хувийг бүрдүүлж байна. Энэ явцад орхигдсон нэг том зүйл бол санхүүгийн зах зээлийн зохистой дэд бүтэц юм. Банкнаас өөр зах, тэр дотроо хөрөнгийн зах зээл хөгжөөгүй нь манай эдийн засагт олон гацаа үүсгэж байгаа. Дурдсан нөөц, хөрөнгийн шилжих, хуваарилах механизм байхгүй байгаатай холбоотой. Үүнээс болж цаашдын хөгжил тодорхой түвшинд очоод зогссон бөгөөд дараагийн шинэ шатанд гарахын тулд шинэ шийдлүүд шаардагдаж байна.

Дээрх зургаас харахад, хөгжилтэй орнуудын санхүүгийн зах зээлд банкнаас гадна хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн болон даатгалын сангууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр сангаар дамжиж хөрөнгө нөөцийн шилжилт, хуваарилалт хамгийн үр ашигтай байдлаар хийгддэг. Тухайлбал, АНУ-ын иргэд хөрөнгө оруулалтын болон тэтгэврийн сангаараа дамжуулан Оюутолгойн толгой компани болох "Рио Тинто" компанийн тодорхой хувийг эзэмшдэг. Тэд Монголын талаар дуулаагүй, хаана байдгийг нь мэдэхгүй байж болох ч, Оюутолгойн уурхайн ашиг орлогоос эзэмшиж буй хувьцаагаараа дамжуулан бодитойгоор хүртэх боломжтой байгаа юм. Харин Монголын төр Оюутолгойн 34 хувийг эзэмшдэг ч одоогийн ард иргэд, ирээдүй хойч үе эх орныхоо нөөц баялгаас хүртэх бололцоо одоогоор алга байна.

Энэ гажуудал, гацааг арилгахын тулд төрийн оролцоог нэмэгдүүлж дахин хуваарилалтын үүргийг гүйцэтгүүлэх бус харин санхүүгийн зах зээлийн механизмыг нь бүрдүүлэх хэрэгтэй байна. Жишээлбэл, нийт ирд иргэдийг орлоготой, амьжиргааны түвшин өндөр байлгах, мөн одоо үеэс ирээдүй хойч үе рүү байгалийн нөөц ашигласны орлогыг хуваарилах зорилгоор Баялгийн өв сан байгуулж болно. Сангийн ажиллах зарчмыг санхүүгийн балансаар дамжуулан харуулбал,

Хөрөнгө	Өр төлбөр
•Ашигт малтмалын салбараас орж ирж буй татварын орлого	Ирээдүй хойч үед хуваарилах хувь
•Татварын орлогоос ирээдүйд ашигтай ажиллах салбарт хийсэн хөрөнгө оруулалтууд	
•Хувьцаа, бонд, бусад санхүүгийн хэрэгсэл	Эзэмшигчдийн өмч
•Стратегийн ач холбогдол бүхий ордуудын төрийн эзэмших хувь, тухайлбал	Монголын иргэдэд олгосон хувьцаа
•Оюу Толгойн 34 хувь	
•Таван толгойн 51 хувь гэх мэт	

Энэ нь байж болох шийдлийн зөвхөн нэг хувилбар бөгөөд ийм төрлийн зөв механизмыг зохих зорилгод нь нийцүүлэн бий болгосноор

• Иргэд уул уурхайн нөөц баялаг, ашиг орлого хувьцаагаар дамжуулж эзэмшинэ

• Ирээдүйн иргэдэд өвлүүлэх механизм бүрдэнэ

• Уул уурхайн салбараас олох орлогыг бусад салбар луу хөрөнгө оруулалт хийх боломжтой болно

Санхүүгийн салбарын зөв тогтолцоог бүрдүүлэх замаар бид хөгжлийн зангилаа олон асуудлыг шийдэж шинэ шатанд гарах болно. ■

## БОДЛОГЫН СУДАЛГАА

## ИТГЭЛ БАС ӨӨДРӨГ ХҮЛЭЭЛТ

“Хэрэглэгчийн итгэлийн индекс” түүвэр судалгааны дэлгэрэнгүй дүгнэлтийг хүргэж байна. Уг судалгааг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн захирал, доктор, профессор Ц.Даваадорж ахлагчтай, доктор, профессор Б.Сувд, доктор, профессор Б.Алтанцэцэг, докторант Д.Баярмаа нарын судлаачдын баг боловсруулжээ. Өнгөрсөн онд эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлэмж эрс сайжирсан байна. Судалгаагаар ядуурлын түвшин буурч байна гэсэн нааштай мэдээг өгчээ.

**Дүгнэлт:**

1. Хэрэглэгчийн итгэлийн индекс /ХИИ/ 133.1 болж, 2011 оны мөн үеийн түвшингээс 13.5 хувиар сайжирсан байна. Индексийн энэхүү өсөлтөд өнөөгийн индекс болон хүлээлтийн индексийн аль алины өсөлт нөлөөлжээ. Ялангуяа өнөөгийн байдлын индексийн 23 хувийн өсөлт түлхүү нөлөөлсөн байна. Энэ үр дүнг 2009 оны дөрөвдүгээр сарын / эдийн засгийн хямралын үе/ ХИИ-ийн судалгаатай харьцуулбал хэрэглэгчийн итгэл гурван жил хагасын хугацаанд 3.6 дахин сайжирчээ.

2. Эдийн засгийн ойрын ирээдүйн талаар хэрэглэгчид өөдрөг хүлээлттэй байна. Ялангуяа өрхийн орлого өснө гэж үзэж буй өрхийн эзлэх хувь 37.2 хувь болж өссөн байна. Харин өнгөрсөн онд бизнесийн нөхцөл болон ажлын байрны олдоцын хувьд хэвийн түвшинд байна гэж үзсэн өрхийн тоо эрс өсчээ. Өнгөрсөн оны аравдугаар сарын байдлаар нийт өрхийн 27.7 хувь нь энэ үеийг

удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжтой үе гэж үзэж байхад 43 хувь нь тохиромжгүй гэж үзсэн байна. Тохиромжгүй гэж үзэж буй өрхийн тоо 2011 он хүртэл буурсан бол өнгөрсөн онд 6.6 хувиар эрс өсчээ.

3. Өрхүүдийн гуравны хоёр нь өнгөрсөн оны аравдугаар сарын байдлаар ирэх зургаан сар болон жилийн хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл, өмнөх онуудтай харьцуулахад илүү олон өрх инфляцийн хүлээлттэй байна гэсэн үг. Харин хүлээгдэж буй инфляцийн түвшин өмнөх оноос буурсан дүнтэй гарчээ. Удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүний эрэлтийн хандлага болон хүлээгдэж буй инфляцийн түвшин нь эдийн засгийн үйл ажиллагааны идэвх өмнөх онтой харьцуулахад буурч байгааг илэрхийлж байж болзошгүй.

4. Өнгөрсөн оны аравдугаар сарын байдлаар ам.долларын ханш зургаан сарын хугацаанд өснө гэдэг хүлээлт өмнөх онтой ойролцоо байсан бол нэг жилийн хугацаанд өснө гэсэн хүлээлт өмнөх онтой харьцуулахад 6.7 хувиар



▸ өссөн дүнтэй гарчээ. Ам.долларын ханш хэрхэн өөрчлөгдөх талаарх асуултад мэдэхгүй гэсэн хариулт судалгаанд өндөр хэвээр байгаа нь ханшийн өөрчлөлтийн талаарх тодорхой бус хэвээр байгааг илтгэж байна.

5. Улаанбаатар хотын өрхүүдийн орон сууцны үнэ болон зээлийн хүүгийн талаарх хүлээлт ихээхэн өөрчлөгдсөн байна. Зээлийн хүү болон орон сууцны үнэ өснө гэж хүлээж буй өрхийн тоо мэдэгдэхүйц нэмэгджээ. Түүнчлэн банкинд итгэх итгэл жилийн өмнөхтэйгээ адил байна. Нийт өрхийн 73.7 хувь нь банкинд төгрөгийн хадгаламж хийх сонирхолтой гэсэн дүн гарчээ. Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин өнгөрсөн оны аравдугаар сарын байдлаар 5.6 хувь байгаа нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 3.3 хувиар бага байна. Ажилгүйдлийн түвшин буурах хандлагатай ч ядуу өрхүүдийн дунд ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байна. Өөрөөр хэлбэл, ядуу өрхийн ажилгүйдлийн түвшин ядуу биш өрхийнхөөс дөрөв дахин өндөр байгаа нь санаа зовоосон асуудлын нэг хэвээр. Хэдийгээр ядуу өрхийн ажилгүйдлийн түвшин 2009 оны аравдугаар сард эдийн засгийн хямралын үеийн түвшин болох 25.9 хувиас буурсаар байгаа ч өндөр үзүүлэлттэй гарчээ. Түүнчлэн орон сууцны нөхцлөөрөө ажилгүйдлийн түвшин ихээхэн ялгаатай байна.

6. Иргэдийн амьжиргааны түвшинг өнгөрсөн онд 126.500 төгрөгөөр авч ядуурлын түвшинг тооцсон. Үүгээр хэмжиж үзэхэд ядуурлын түвшин өмнөх оноос буурч 22.7 хувь болсон байна. Судалгааны дүнгээс харвал эдийн засгийн нөхцөл сэргэж байгаатай холбоотойгоор өрхийн амьжиргаа дээшилж, ядуурлын түвшин буурч байна гэж дүгнэж болохоор. Ядуурлын түвшин нь ямар ч үед боловсролын түвшин, орон сууцны нөхцөл болон ажил эрхлэлтийн байдлаас ихээхэн хамаарч ялгаатай байсаар ирсэн болохыг онцлоё.

7. ХИИ судалгааны динамик үзүүлэлтээс харахад ажил эрхэлдэг өрхийн тэргүүнтэй өрхүүдийн ядуурлын түвшин буурсан бол ажил эрхэлдэггүй өрхийн тэргүүнтэй айлын ядуурлын түвшин хэлбэлзэмтгий байна. Эндээс харахад өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг байх нь тухайн өрхийн амьжиргаанд, улмаар ядуурлын түвшинд чухал нөлөөтэй аж. Бүхэлд нь авч үзвэл, өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг болон ажил эрхэлдэггүй

өрхүүдийн ядуурлын түвшний ялгаа өндөр хэвээр байна.

8. Судалгааны үр дүнгээс харвал өрхүүд Төвбанкны бие даасан байдал хангалтгүй гэж үзэж байна. Түүнчлэн өнгөрсөн оны өндөр инфляцид эрэлтийн хүчин зүйл нийлүүлэлтээс илүү нөлөөлсөн гэж үзэж байна. Хүмүүсийн эдийн засгийн идэвхийг бууруулж байгаа гол шалтгаан нь төрийн халамжийн бодлого болон мэдээллийн дутмаг байдал гэж дүгнэсэн байна.

## Бодлогын зөвлөмж:

1. ХИИ түүвэр судалгаа нь макро эдийн засгийн бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой. Тиймээс эдийн засгийн ерөнхий байдалд хэрэглэгч хэр зэрэг итгэлтэй байгааг мэдээллээр хангадаг. Дээр дурдсанчлан, Монголын эдийн засаг богино хугацаанд ихээхэн өөрчлөлттэй байдаг тул бодлого боловсруулагчдад эдийн засгийн тухайн байдалд тохирсон бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах үүднээс ХИИ түүвэр судалгааны давтамжийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

2. ХИИ судалгаа нь өрхийн орлого, ажил эрхлэлт болон тэдгээрийн өөрчлөлтийн талаар чухал мэдээллийг өгдөг. Судалгааны үр дүнгээс харахад, өрхийн шинж чанарууд бүлгээр ялгаатай байна. Иймд нийгмийн хамгааллын бодлогын үр ашгийг нэмэгдүүлэх болон зардлыг бууруулах үүднээс зорилтот болгох шаардлагатай. ХИИ судалгааны мэдээлэл болон үр дүнг нийгмийн хамгааллын бодлогыг боловсруулахад хэрэглэж болно.

3. Ажилгүйдлийн түвшин буурах хандлагатай байгаа ч тухайн хүний боловсролын түвшин, орон байрны нөхцөл, хүйсийн байдлаас хамаарч ялгаатай байгааг ажилгүйдлийг бууруулах бодлогод тусгах шаардлагатай. Хүмүүсийн эдийн засгийн идэвхийг сайжруулахад хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хавтгайрсан халамжийг бууруулах нь зүйтэй.

4. Инфляцийг бууруулахад мөнгөний бодлогод итгэх хүмүүсийн итгэл чухал хүчин зүйл болдог. Төвбанкны бие даасан байдал нь мөнгөний бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлж бодлогын үр нөлөөг сайжруулдаг. Иймд Монголбанк үйл ажиллагаагаараа хараат бус гэдгээ нотлон харуулах шаардлагатай. ■



The  
Economist

# УЛСЫН МӨХӨЛ



“The Economist” сэтгүүлийн хоёрдугаар сарын 23-ны дугаарт нийтлэгдсэн Сирийн одоогийн нөхцөл байдал болон Испани улсын эдийн засгийн талаарх нийтлэлийг орчуулан хүргэж байна.

Орчуулсан Б.ЗАЯА

## Сири улсын задрал Ойрхи Дорнодод аюулын харанга дэлдэж байна

Дэлхийн I дайны дараа Сири Оттоманы эзэнт гүрний мэдлээс гарч, II дайны дараа тусгаар тогтнолоо олсон байдаг. Харин өнөөдрийн энэ дайны дараа тус улс оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй болжээ.

Турк, Ливан, Йордан, Ирак, Израйлийн дунд орших Сири улс хүн төрөлхтний нүдэн дээр бутран сарниж байна. Сирийн Ерөнхийлөгч Башар Ассадын дэглэм нуран унаж эсвэл тус улс түүний дэглэм дор одоо байгаа цэрэг зэвсгийн хүчээ ашиглан хэсэг хугацаанд тэмцэж болох хоёр зам бий. Эдгээрийн аль ч замаар явсан Сирийн цаашдын ирээдүй тун бүрхэг байна. Левантын зүрхэн дэх шинэ Сомалийн исламчуудын өгөөш, золиос болон үлдэх боломж өндөр байна.

Ийм зүйл тохиолдвол сая сая хүний амь нас сүйднэ. Мөн Дундад Азийнхны дундах ширүүн өрсөлдөөний галыг улам дүрэлзүүлнэ. Ноён Ассадын химийн зэвсгүүд одоо аюулгүй ч, цаашид хэн нэгэн буруу хүний гарт орох эрсдэлийг үгүйсгэх аргагүй. Энэ нь Ойрхи Дорнодын төдийгүй, дэлхий дахины асуудал юм.

## Дамаскаас гарах зам

Барууныхан Сирид тусламж үзүүлэхгүй байгаа, тэдний эргэлзээг төрүүлэх болсон нэг шалтгааныг 2011 онд дайн эхлэх үеэс л ноён Ассад хүчирхийллийн стратегийг сонгосон

явдалтай холбон тайлбарлаж болох юм. Тэрбээр “Араб спринг” бослого хөдөлгөөнд буу, танк ашиглан дайралт хийснээрээ тайван жагсагчдыг зэвсэглэсэн арми болгон хувиргасан юм. Хотууд руу гал нээснээрээ үй олон хүний амь насыг сүйдэлж, үлдсэн оршин суугчдад хүчээр нүүхээс өөр сонголт өгөөгүй. Үүндээ Жихад бүлгийнхнийг татан оролцуулж, мөн бусад шашны бүлэглэлийн хүмүүсийг өөрийн талд оруулахаар ятгаж дөнгөжээ.

Сирийн цус хаалтгүй урсч, шашны бүлэглэлүүдийн өшөө хорсол асч байна. Тулаан цаашид хэдэн жилээр ч үргэлжилж магадгүй.

Босогчдын бүлгүүд сүүлийн үед цэргийн баазууд руу дайрч, эрхшээлдээ оруулах болжээ. Хойд болон зүүн зүгийн нутгийн ихэнх нь тэдний мэдэлд орж. Одоо харин том хотууд руу давшиж байна. Босогчдын бүлгүүд (үүнд Засгийн газрын армиуд мөн багтана) хоорондоо хагаралдаж, нэг нэгнээ онилох болжээ.

Ассад өөрийн улсаа удирдаж чадахгүй байгаа ч түүнд тулалдах шалтгаан олон бий.

Түүний мэдэлд сайн зэвсэглэсэн үнэнч 50.000 цэргээс гадна итгэл муутай, зэвсэг тааруу хэдэн арван мянган цэрэг бий. Түүний арыг даах, мөнгө, зэвсэг, зөвлөгөө, хүн хүч өгч тусалдаг Орос, Иран, Ирак зэрэг орны хамсаатнууд байгаа. Ливаны хамгийн хүчирхэг арми болох Хезболлах өөрийн цэргүүдээ мөн илгээж байгаа аж. Ноён Ассад энэ дайнд ялахгүй нь бараг тодорхой ч түүний ялагдал иртэл бас нэлээд хугацаа шаардагдана. ▶



► Одоогийн байдлаар дайны улмаас 70.000 гаруй хүн амь насаа алдаж, хэдэн арван мянган хүн ор сураггүй алга болоод байна. Сирийн хоёр сая гаруй хүн орон гэргүй болж, хоол хүнс, орон байрны эрэлд хатаж байгаа аж. Хилийн гадна мөн сая гаруй хүн ядуу, зүдүү байдалтай амьдарч байна. Үүн дээр Ерөнхийлөгч Барак Обама “Зөвхөн хүний амийг аврах нь цэргийн ажиллагаа явуулах хангалттай үндэслэл шалтгаан биш” гэсэн байр суурьтай хандаж байгаа аж. Энхтайвныг тогтоох нь ямар хэцүү зүйл юм бэ гэдгийг Афганистан, Иракийн дайнаас ухаарсан АНУ-ын удирдагчид ноён Ассадын эхлүүлсэн энэхүү замбараагүй байдалд оролцохоосоо эмээх нь аргагүй. Обама АНУ-ын эдийн засгийн дайнд ялалт байгуулахаар сонгогдсон билээ. Түүний бодлоор “АНУ эхлээд өөрийнхөө асуудлыг шийдсний дараа л бусад орны асуудалд оролцож болох юм. Одоо харин аливаа орны асуудлаас холуур байх нь зүйтэй” аж. Уг шийдвэрийг ойлгож болох ч алдаатай байгааг ажиглагчид шүүмжилж буй. Дэлхийн хүчирхэг гүрэн гэдэг утгаараа Америк хэзээ гэдэг нь тодорхойгүй ч Сирийн асуудалд оролцох нь дамжиггүй. Хэрэв зөрчилдөөн цаашид үргэлжилсээр байвал Сирийн байдал дордсоор л

байна. Сири эцэстээ дайны эдлэн болж хувирна. Сирид терроризмийг таслан зогсоох, эрчим хүчээр хангах, үй олноор устгах зэвсгийн тархалтаас урьдчилан сэргийлэх гэсэн АНУ-ын зорилтуудын туулах зам уртасч, хүрэхэд илүү хэцүү болно. Ливаны 15 жил үргэлжилсэн иргэний дайныг санагдуулахуйц Сирийн зөрчилдөөн, түүний задрал дэлхий нийтийг түгшээж байна.

Босогчдын тавны нэг нь Жихад бүлгийнхэн бөгөөд хамгийн сайн зохион байгуулалттай хүмүүс аж. Тэд сиричүүд болон “Sunnis” бүлгийг захирах санаа агуулж байгаа бөгөөд хууль дүрэмгүй Сирийн газар нутгийг терроризмын үүр болгон ашиглаж магадгүй юм. Хэрэв тэд Голан Хэйтийн бүс нутгийг даван Израйльд заналхийлвэл израильчууд өөрсдийгөө хамгаалах нь тодорхой. Хуваагдсан Сирийн уршгаар Ливан бутарч магадгүй. Учир нь ноён Ассад Ливанд байгаа өөрийн хүмүүсээ хөдөлгөөнд оруулж мэднэ. Йордан улс босогчид болон Ислам шашинтнуудын нөлөөгөөр тогтворгүйжнэ. Ингэснээр зөрчил улам хурцадна. Ассадын химийн зэвсгийн нөөцийг хүлээн зөвшөөрснөөрөө Иранийг цөмийн зэвсэгтэй болгохоос сэргийлэх АНУ-ын зорилгод саад учирна. Ноён Обама Сириэс зайгаа барихыг хүссэн. Гэвч Сири түүнийг өөрөө олоод очно. ►►

### ► Юу ч хийхгүй байх нь бас нэг бодлого

АНУ-ын зүгээс өнгөрсөн оны аравдугаар сард Сирийг нислэггүй бүс болгоно хэмээн анхааруулж байсан бол байдал одоо бүр илүү аюултай болжээ. Сири улс дэгдээсэн түймэртээ өөрөө шатаж үгүй болохыг хүлээж байсан ноён Обамагийн бодол биелэлээ олохгүй нь. Байдал улам дордохоос өмнө



тэр ямар нэг арга хэмжээ авах хэрэгтэй болоод байна.

Ерөнхийлөгч Обамагийн зорилго Сириэс үлдсэн зүйлийг хямгадан хадгалахад оршиж байвал зохилтой. Энэ нь ноён Ассадын эргэн тойронд байгаа хүмүүст өөрсдийнх нь сонголт буруу гэдгийг ойлгуулах, босогчидтой хэлэлцэх анхны алхам бол Ассадын гэр бүлийг хөөн зайлуулах гэдэгт ятган итгүүлнэ гэсэн үг юм.

Нислэггүй бүс нь ноён Ассадын нисэх хүчний нислэгийг хориглох, түүний зарим пуужинг устгахад шаардлагатай хэвээр байгаа аж. Энэ нь Америкийн зүгээс Ассадын дэмжигчдэд өгөх жинтэй дохио болох юм. Мөн Жихадаас бусад бүлгийн үйл ажиллагааг дэмжих хэрэгтэй. Уг санааг Европын бусад улс сайшаахгүй ч Франц, Их Британи дэмжинэ. ОХУ Обамагийн эсрэг байр сууриа илэрхийлж, Ассадын талд зогсдог. Гэсэн ч Европ болон АНУ эрх чөлөөт Сири улсыг бий болгохоо амлан, Ассадыг бууж өгөхийг үргэлжлүүлэн ятгах хэрэгтэй.

Дээрх ятгалга амжилтгүй болж, Ассад одоогийн байр сууриндаа хэвээр үлдсэн байлаа ч Сирийн бүлэглэлүүдтэй харилцаа тогтоох боломж нээгдэх юм. Энэ нь АНУ Сирид өөрийн туслахтай болно гэсэн үг. Өнөөдөр Сирийн удирдагчид бүрэн орхигдсон байдалтай байна. ■

## ИСПАНИ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

# ШИНЭ ГЕРМАН БОЛОХ ХАРААХАН БОЛООГҮЙ

Орчуулсан Р.ГАНТУЛГА

### Зарим талаараа сайн байж болох эдийн засгийн түүх

Испани сүүлийн үед Германы араас ороод байна уу. Испанид ажилгүйдлийн түвшин 26 хувьд арай ч хүрэхгүй байх гэж найдаж суухаас. Өнгөрсөн оны

IV улиралд тус улсын ДНБ 0.8 хувиар буурсан үзүүлэлтэй байв. Гэсэн ч тус улсын өнөөгийн байдал зарим талаараа арван жилийн өмнө Герман ямар байсан тэр үеийг санагдуулж байгаа юм. Тэр үед Герхард Шредер эдийн засгийн хямралд орсон Европын нэгэн улсыг хамгийн хүчирхэг эдийн засаг

бүхий гүрэн болгон өөрчлөх реформыг нэвтрүүлж байжээ. Испанийн Ерөнхий сайд Мариано Рахойгийн Засгийн газар хөдөлмөрийн хуулийг сулруулж, төсвийн зардлыг танах зэргээр ихээхэн хичээл зүтгэл гаргаж буй нь герман маягийн гайхамшиг бүтээхийг зорьж байгаа нь илт. ►

► Ерөнхий сайд Ражой Испанийн эдийн засгийг хямралаас гаргаж чадна гэж хэлсэн. Хэдийгээр хүчтэй биш ч тодорхой хэмжээний ахиц, дэвшил гарч буйг илтгэх анхны шинж тэмдэг харагдах болсон нь үнэн. Хөдөлмөрийн нэгж зардал хэсэгчилсэн байдлаар буурч байгаа нь бүтээмж нэмэгдэж байгаатай холбоотой. Одоогийн тайлан, тооцоо нааштайгаар эргэж байгааг ч мөн харж болно. Хэдийгээр ажилгүйдлийн түвшин нэмэгдэж байгаа ч хувиараа бизнес эрхлэгчдийн тоо харьцангуй нэмэгдэж эхэлсэн.

“Morgan Stanley” компанийн ахлах эдийн засагч Иойким Фельс “Өнгөрсөн арван жилд Германд тохиолдсон олон зүйл одоо Испанид биелэлээ олж байгаа боловч энэ тохиолдол цаг хугацааны хувьд маш хавчигдмал, дэлхий даяараа хүндхэн байдалтай байгаа үед тохиож буйгаараа онцлог юм” гэж хэлсэн нь Испанид хөдөлмөрийн зардал багасч, экспорт нэмэгдэж, машины үйлдвэрлэлд огцом өсөлт гарч байгааг онцлон тэмдэглэж буй ажээ. Тэрбээр “Испанийн хувьд Герман шиг болно гэдэг хоёроос дөрвөн жилийн хугацаа зайлшгүй шаардагдана” гэж нэмж хэлсэн байна. Иойким Фельс бол Германы эдийн засгийн онолыг дэмжигчдийн нэг юм.

Гэхдээ л хоёр улсын хоорондох

ялгаа асар их. Испанийг бодвол Германы боловсрол, сургалтын тогтолцоо ажилтай болох боломжийг илүү сайн бүрдүүлж өгдөг. Германы хувьд татварыг бууруулсан нь эдийн засаг эргээд сэргэх гол түлхэц болсон байна. Испани улсын хувьд төсвийн алдагдал 2012 онд ДНБ-ий 6.7 хувьтай тэнцэж байв. Гэтэл Ерөнхий сайд Ражой уг алдагдлыг багасгахын тулд татварыг нэмсэн. Тэрбээр бүтэц, зохион байгуулалтын төсвийг их хэмжээгээр багасгасан нь дэвшилтэт эдийн засгийн хувьд анхны тохиолдол гэдгийг ч дурдаж байв. Гэхдээ эдийн засгийн хатуу бодлого баримталж, хэт их хэмнэлт гаргаж байгаа нь хэрэглэгчдийн худалдан авалтыг огцом бууруулахад нөлөөлж байна. Мөн тус улсын хамгийн том зах зээл болох Евро бүс рүү гаргадаг экспорт ч гацаанд ороод байгаа нь эдийн засгийг улам хямруулж байна.

Эдийн засгийн хатуу бодлогыг цаашид улам чангаруулах хүлээлттэй байгаа учраас татварын хэмжээг багасгах талаар яриад ч хэрэггүй. Худалдааны татвар мөн л нэмэгдэх болсон нь үнэндээ Европын холбооноос үзүүлж буй дарамт шахалттай холбоотой. Испанийн банкууд Европын мөнгөн тусламжийг хүртэх болсноос хойш өөрсдийн данс, тооцоондоо

бүрмөсөн цэвэрлэгээ хийх болсон бөгөөд эдийн засгийн өсөлт зээлийн дарамт шахалтад орсон байна. Ялангуяа ажлын байр хамгийн ихээр бий болгодог жижиг, дунд үйлдвэрлэл, хувийн хэвшлийнхний хувьд төвбанкны бодлогын хүү еврогийн дунджаас хавьгүй өндөр байгааг ОУВС онцолжээ.

Харин тус улсын Засгийн газар эдийн засаг энэ жилийн сүүлчээр, аль эсвэл дараа жил өсөх болно гэсэн мэдэгдэл хийв. Харамсалтай нь эдийн засгийн сэргэлт эхлэхээсээ өмнө маш хэврэгхэн байгаа нь тодорхой байгаа юм. Еврогийн шок улам нэмэгдвэл тус улсын эдийн засаг урагшлах биш харин ч эсрэгээр навс унах аюултай. Энэ тал дээр ялангуяа Италийн Засгийн газар маш их санаа зовниж байна. Хэрэв Газрын дундад тэнгисээр хиллэсэн Испанийн хөрш болох, саяхан сүр дуулиант сонгууль болж өнгөрсөн Италид бондын зах зээлийн итгэл алдрах аваас халдвар бүр ч газар авах нь тодорхой. “Spiro Sovereign Strategy” зөвлөх компанийн тэргүүн Николас Спиро Испанийн үндэс суурь Италитай харьцуулахад муу гэж үзэж байгаа бөгөөд тэрбээр “Хоёр улсын хоорондох ялгаа төдийлэн ажиглагдахгүй хэвээр л байна. Аливаа улсад тохиолдсон зовлон зүдгүүр өрөөл бусдыг чирдэг эрсдэл байнга гардаг” гэж хэлжээ.

Испанийн эдийн засаг дахин өслөө ч энэ нь ажлын байр бий болгож, хүмүүсийн итгэл найдварыг дахин босгоход хангалттай байх болов уу. Эдийн засагч Лорензо Берналдо де Куйрос хөдөлмөрийн реформын талаар “Ажлын байр бий болгоход 2.5 хувийн эдийн засгийн өсөлт шаардагддаг байсан бол одоо 1.5 хувь байхад л хангалттай” хэмээн итгэл төгс хэлж буй нэгэн. Зарим шинжээчийн үзэж буйгаар Испанийн ДНБ энэ жил 1.5 хувиар агших ажээ. Харин 2014 онд эдийн засаг нь ямар байхыг төсөөлөх нь одоогоор боломжгүй зүйл юм. Яг л Германд 2003 онд тохиолдож байсан шиг Испанийн өмнө туулах урт бөгөөд бартаат зам зурагсаар. ■





Фотог Э.Зоригт

## ЗАХИРЛУУД

# “ХҮНД ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭЖ, СЭТГЭЛТЭЙ БОЛГОХ МАШ ЧУХАЛ”

### И.ОТГОНЖАРГАЛ

Манай энэ удаагийн “Захирлууд” буланд “Номин холдинг” ХХК-ийг үүсгэн байгуулж, өнөөдрийн өндөрлөгт хүргэхэд ухаан бодол, биеэ чилээсэн Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан, УИХ-ын гишүүн асан А.Шагдарсүрэн уригдан оролцлоо. Ерээд оны дундуур “Номин-5” нэртэй ХЭАА-н гэрчилгээ гардан авч, бизнесээ эхэлсэн түүнийг өдгөө “Номин холдинг” гэсэн 4500-гаад ажилтантай өнөр гэр бүлийн өрхийн тэргүүн гэж хэлж болно.

Түүнчлэн Шагдарсүрэн захирлыг гэр бүлийн бизнесээ эхлүүлж байх үед ном эрдмийн мөр хөөх насанд явсан Ш.Уламбаяр, Ш.Баярсайхан, Ш.Энхбаяр гэсэн гурван хүү нь өнөөдөр Монголын худалдаа, үйлдвэрлэл, барилгын салбарт тод мөрөө гаргасан шинэ үеийн томоохон бизнесмэнүүдийн төлөөлөл болж чаджээ. Тиймээс “Номин холдинг”-ийн Шаагаа зөвлөхийн удирдлагын арга ухаан, бизнесийн туршлага, амжилтын нууцаас хуваалцаж байна. ▶

## ► Бизнесийнхнийг тамладаг хүнд суртал амь бөхтэй хэвээр байна

-“Номин холдинг” компанийн түүхийг унших надад сонирхолтой байсан л даа. Таван хүний бүрэлдэхүүнтэй тухайн үеийн ХЭАА-н үйл ажиллагаа нэг, хоёр лангуу, нэлээд хэдэн тасаг гээд өргөжөөд явсан байдаг. Жилээс жилд ажилтны тоо өсч, үйл ажиллагаа өргөжихийн хэрээр мөнгөнөөс илүү удирдлагын арга барил, хүний нөөц гээд санаа зовоох олон асуудал ар араасаа хөвөрч байсан байх. Тухайн үед танд ийм зүйлийг зохицуулахад хэцүү байсан уу. Ямар арга барилаар амжилттай удирдаж ирсэн бэ?

-Жилээс жилд хүний тоо зуу, зуугаар л нэмэгдэж байгаа юм л даа. Мэргэжилтэй, мэргэжилгүй, ажил хийж үзээгүй, туршлагагүй янз бүрийн хүн ирнэ. Хамгийн гол нь хүмүүстээ итгэл үзүүлээд, сургана. Дотоод, гадаадын туршлагыг зааж өгнө. Юм үзэж, нүд тайлуулна. Өнөөдөр “Номин холдинг”-ийн 4500 орчим ажилтны 3000 гаруй нь худалдаанд ажиллаж байна гэж бодоход бид тэрнээс хэд дахин олон хүнийг зах зээлийн өрсөлдөөнт нийгэмд худалдааг ингэж зохион байгуулна гэдэг тал дээр сургасан. Хүн нэг ажлыг хийгээд ирэхээр тэртээ тэргүй туршлага сууж, өсөж өндийдөг. За тэгээд тэр хүмүүс шинийг сурч мэдчихээд “Номин”-д насаараа байхгүй. Өөрөө бизнес эрхлээд гарна. Энэ утгаараа олон хүн бэлтгэгдсэн. Бэлтгэгдэнэ гэдэг бол тухайн хүн ажлын байран дээрээ сурч байна, бид ч хүнээ сонгож авна. Итгэл хүлээлгэнэ, ажлыг нь тодорхой үр дүнгээр хэмжинэ.

Сайн ажилтанд шагнал, урамшуулал өгнө. Цалинг нь хийж бүтээж байгаа ажлын гүйцэтгэлтэй нь уяна. Хүний гаргасан хөлс хүчинд тохирсон цалин өгнө гэдэг бол урамшуулал л даа. Мөнгө өгсөн болоо гээд орхичихгүй. “За, чи ингэж сайн ажиллалаа, сайн байна. Харин чи ингэж муу ажиллалаа гэдгийг нь хэлнэ. Төгс хүн гэж байхгүй учраас үнэхээр сайн байгааг нь сайшааж магтахад үг харамлахгүй, муу байгааг нь нүүрэн дээр нь хэлээд, засаж залруулаад явах. Манай хүмүүс дандаа хамтран ажиллах явцдаа өсөж хөгжсөн. Бид ч тэр дунд өөрсдөө өсч, хөгжиж байгаа.

Хүн удирдах, байгууллага авч явах тал дээр миний хувьд ор хоосон биш, туршлага байсан. Социализмын үед сургуулиа төгсөөд, Байшин үйлдвэрлэх комбинат, Хотын барилга трестед тус тус инженер байсан. Мөн Үйлдвэрчний төв зөвлөлд салбарын Төв хороо гэдгийг удирдаж байлаа. Үйлдвэрчний эвлэлийн хийдэг гол ажил нь социалист уралдаан гэж байсан. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нормчлол зэргийг Үйлдвэрчний эвлэл л гартаа барьж байлаа. Орчин үед залуучууд тэр социалист уралдаан гэдгийг муухай, огт хэрэггүй зүйл мэт төсөөлж болохгүй. Зах зээлийн нийгэмд социалист гэдэг нэр нь л өөрчлөгдөж байгаа болохоос жинхэнэ шударга өрсөлдөөн чинь тэр байхгүй юу.

**-Шударга өрсөлдөөн гэснээс таныг бизнесээ**

эхлээд, өргөжүүлээд явж байх ерээд оны дундуур бизнесийнхний дунд өрсөлдөөн хэр байсан бэ. Миний харж байгаагаар өнөөдөр шударга байцгаая гэж яриад байгаа хэрнээ нэгнээ усалж, хурцалдаг тэрхүү шударга өрсөлдөөн улам өнгө алдаад байх шиг санагддаг л даа.

-Биднийг хөгжүүлсэн юм энэ. Тэр үед электрон барааны цөөхөн дэлгүүр байсан. “Женко”, одоогийн BSB, “Номин электроникс”, “Наран электроникс” гээд л болоо. Хоорондоо шударга өрсөлдөнө. Үгсэн хуйвалдахгүй, дэлгүүр, лангууны зохион байгуулалт, оруулж ирж байгаа бараа, боловсон хүчнээрээ өрсөлддөг байсан. Гэхдээ бас хоорондоо бараа солилцдог. Одоо бол тийм харилцаа огт алга. Нэг нь “Sharp” оруулсан бол тэрүүгээрээ, эсвэл “Samsung” бол тэрүүгээрээ дагнаад байна. Хуучин электрон барааны дэлгүүрт орсон хүн “Sharp” ч авдаг, “Sony” ч авдаг байсан. Тэр үед барааны нэр төрөл ч цөөхөн байсан болоод тэр байх. Явцын дунд зарим өрсөлдөгч гарч ирсэн ч нэг их амжилт олохгүй алга болж байх жишээтэй. Сайн боловсон хүчнээ бие биенээсээ татахыг хичээнэ. Эндээс би зах зээлийн нийгмийг шударга өрсөлдөөн хөгжүүлдэг гэдгийг л хэлэх гээд байна.

**-Одоо тэгвэл шударга өрсөлдөөн ямар байна вэ?**

-Өнөөдөр шударга өрсөлдөөн тэр болгон байхгүй байна. Ямар ч боловсруулалтгүй хонины ноос гадагшаа гарч байна. Уг нь бол гарах ёсгүй бараа шүү дээ. Гаалийн хяналт хаана байна вэ. Хулхи бараа орж ирсээр. Овор ихтэй зүйл яагаад тонн тонноороо гараад байгаа юм бол. Энэ чинь нөгөө л хээл хахуультай холбоотой. Авлига тийм л хүчтэй байна шүү дээ.

**-Ялангуяа хүнсний худалдаан дээр чанар, стандарт маш чухал. Нөгөө талаасаа манай хүнсний бүтээгдэхүүний хангамжийн ихэнх нь импортоор хангагддаг болохоор хэрэглэгчдийн хувьд чанарт итгэхэд бэрх. Энэ тал дээр “Номин” хэр шаардлага хангасан байдаг вэ?**

-Манайх Монголд номер нэг гэж хэлж болох лабораторитой. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний чанар гэж байна. “Эрдэнэт хивс” гэхэд ямар ч будаг ороогүй хонины ноосон бүтээгдэхүүн хийж байна шүү дээ. Энэ бол чанартай, гадаадад нэр хүнд олох бүтээгдэхүүн. Манай импортын барааны хувьд өөрийн зориулалтын тээврээр ирээд, шууд агуулахад буудаг. Бид өнөөдөр Европ, Ази, Америк зэрэг орны хэдэн зуун компаниас бараа оруулж ирж байгаа. Ялангуяа тээвэрлэлтийн онцгой нөхцөлтэй бүтээгдэхүүн дээр цаг хугацаанд нь зориулалтын тээврээр л авахгүй бол осолтой. Манайх хадгалалтын өндөр түвшинтэй учраас боломжийн. Өөрийн гэсэн зориулалтын тээвэргүй, агуулах савгүй газрын хувьд бол маш хэцүү.

Манайд гаднын олон зуун түншээс гадна дотоодын 5000-6000 хувиараа бизнес эрхлэгч бараа нийлүүлж байна. Хэрэглэгч байхгүй бол худалдааны бизнесийн тухай яриад ч хэрэггүй. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг гаднын тэр олон компани хангаж байна шүү дээ. Өнөөдөр нийгэмд “Номин”-гийнхон хуурамч бараа зардаггүй, хулхиддаггүй, чанартай, найдвартай гэсэн ►

▶ баталгаа бий болсон гэдэгт итгэлтэй байна. Энэ бол хэрэглэгчдэд аяндаа ойлгогдож байгаа зүйл. Манай компанийн уриа бий. “Бадрангуй тэмүүлэлтэй, ёс суртахуунлаг, бүтээлч хамт олон байна” гэсэн. Бадрангуй тэмүүлэл гэдэг нэлээд хүч өгдөг. Зүгээр нэг зүйл мөрөөдөөд хаячих биш. Нэг юманд зорьсон бол түүнийгээ төгс болгох. Үлгэр жишээ байлгах хэмжээнд хүргэх. Өнөөдөр их ашиг олоод маргааш нь байхгүй болох тийм зүйл байж болохгүй. Бизнес тэмдгийн хортой, цээрлэдэг зүйл тэр.

**-Хүнийг таньж мэдэж сонгох, сонгосон хүнээ сайн ажиллуулах гэдэг бол нэлээд арга ухаан зарсан ажил. Энэ тал дээр Та юу зөвлөх вэ?**

-Тогтвор сууршил гэдэг бол чухал. Түүнээс гадна “Номин”-д ажиллаж байгаа хүн “Номингоо” гэсэн элэгтэй байх ёстой. Ажилдаа сэтгэлгүй бол түүнд хэчнээн цалин урамшил өгөөд хэрэг байхгүй. Гэхдээ “Номингоо” гэх элэгтэй болгож бас болно. Хоёрдугаарт, хэнийг ямар ажил, албан тушаал дээр тавибал үр дүн гаргах вэ гэдэг маш анхаарах зүйл. Энэ ажил, албан тушаал дээр тавибал үр дүн гаргах уу, үгүй юу гэдгийг сайтар тунгаан бодож, зөв шийдэх. Тэгээд боловсон хүчин мэргэшээд, тогтвор сууршилтай ажиллаад ирэхээр үр дүн нь хэмжих хэмжүүртэй байх. Мэдээж өнгөрсөн жил борлуулж байснаас илүүг борлуулах, илүү бүтээл, ашиг гаргах ёстой. Энэ бол маш тодорхой хэмжүүр. Хүн бүрийн хувийн зан араншинг засахад хэцүү шүү дээ. Үр дүн гарч байгаа бол тэр хүний хурц ааш занг алгуур засах, түүнтэй нь тохирч болдог. Тийм учраас сургах боловсруулах, итгэл хүлээлгэх, сэтгэлтэй болгох л хамгийн чухал. Сэтгэлтэй болоогүй хүн бүтээл гаргах тухай ерөөсөө байхгүй. Арвилан хэмнэх ухаанаар жишээ татаад үзье л дээ. Арвилан хэмнэж чадахгүй хүн бол хэчнээн олоод яахын. Олохын утга байхгүй. Электрон барааны худалдаа цахилгаан их зарцуулдаг. Тэгэхээр эрчим хүч хэмнэх сэтгэл манай электрон барааны худалдагчид бий болох ёстой. Тэр бол нөгөө “Номингоо” гэсэн сэтгэл байна шүү дээ. Сэтгэлгүй хандвал “Номин”-д хохиролтойгоос гадна нийгэмд хохиролтой. Ажил дээрээ тийм хэвшилд сураагүй хүн гэртээ очоод сурна гэж байхгүй. Гэртээ нэг өөр, ажил дээрээ нэг өөр байна гэж худлаа.

Мөн ёс суртахуун гээч зүйлийг сайн бодох хэрэгтэй. Манайд ёс суртахууны дүрэм гэж байдаг. Ёс суртахуунтай байна гэдэг ажилд хандах хандлагад чухал нөлөөтэй. Манайх бол анхнаасаа ажлын байранд архи, тамхи



хэрэглэхтэй эвлэрээгүй. Архи уудаг, бусдыгаа муу зүйлд уруу татдаг хүн бол ажилдаа хэчнээн сайн байлаа гээд тэр хүнээс салахаас аргагүй. Ер нь тийм зарчим барьж ирсэн. Би түрүүн номноосоо харж байлаа л даа. 1997 онд бид Улаанбаатар хотын худалдааны байгууллагыг уриалж, үүрэг авч байсан байх юм. Архи, тамхигүй орчин бүрдүүлье гэж уриалж байж. Үүнээс гадна 1996 онд манайхыг ТӨХ-ноос шилдэг хөрөнгө оруулагчаар шалгаруулж байсан байна.

**-Сонин юм байна шүү.**

-Бид үйл ажиллагаа явуулаад хуримтлал бий болохын хэрээр хувьчлалд оролцсон. 1999 онд анхныхаа үйлдвэрийг хувьчилж авсан. “Эрдэнэт хивс” ХК-ийн хувьцааны дийлэнх хувийг, “УИХ дэлгүүр” ХК-ийн хувьцааг худалдаж авсан. Энэ маягаар хувьчлалын ажилд идэвхтэй оролцсон. Анхны дуудлага худалдаа болоход идэвхтэй оролцож өөрийн байр савтай болж байсан.

**-Өнгөрсөн онд Номин холдинг улсад хэчнээн төгрөгийн татвар төлсөн бэ?**

-36 тэрбум төгрөг төлсөн. Мөн өнгөрсөн онд 500 айлын орон сууц ашиглалтад оруулсан. “Эрдэнэт хивс” компани төлөвлөгөөгөө бүх нэр төрөл дээр давуулан биелүүлсэн байна. ▶

## ► Монгол Улс хуулиар явах ёстой байтал заавраар явдаг болсон

### -Бизнесийн орчин өнөөдөр ямар байна вэ?

-Бизнесийн орчны хамгийн хүнд үеийг бид даван туулсан. Одоо гайгүй болох тал руугаа явж байна. Тусгай зөвшөөрөл, хүнд суртал биднийг тамладаг. Тухайлбал, сая манай менежер мэргэжлийн хяналтаас бүтээгдэхүүнээ лабораторит шинжлүүл гэсэн бичиг авахын тулд гурван өдөр хаалгыг нь сахисан байх жишээтэй. Энэ барааг шинжлүүл гээд бичиг өгөхөд гурван өдөр хүлээлгэж байна гээд бод доо. "Гурван минутад өгчих юмыг гурван өдөр хүлээлгэнэ гэсэн чинь юу гэсэн үг вэ, ярьж хэлдэг газар нь хэлье" гэхээр манай хүмүүс "Сүүлд нь тэрнээсээ эс юм болно" гээд эмээж байна. Дахин чангалуулахаасаа айж байна л даа. Зүрхэнд нь орчихсон байна гэсэн үг. Гэтэл бизнесийнхэнд цаг, минут бүр үнэтэй атал төрийн албаны хүнд сурталтнуудад өдөр, хоног бол юу ч биш байна шүү дээ. Энэ бол бизнесийн маш том саад. Одоо ч амь бөхтэй байсаар. Ном журмаараа явж байгаа юманд авлига өгөх тухай яриа байхгүй. Шударга бус юманд л авлига өгөөд байгаа.

### -Та 2000-2004 онд УИХ-ын гишүүн байсан. Тэр үед энэ мэтийн бизнест чөдөр тушаа болдог зүйлийн талаар хэр ярьж, хуульд тусгуулж байсан бэ?

-УИХ-д ороод миний анхны хийсэн зүйл энэ. Тусгай зөвшөөрлийн хуулийг гаргасан. Намайг Парламентад байх үед дэлгүүр битгий хэл, лангуу ажиллуулахад лиценз гэдэг юм дүүргээс өгдөг байлаа. Тэр нь 3-6 сарын хугацаатай. Тэгээд л ямар нэгэн шалтаг гаргаад нэг байцаагч нь гэнэт орж ирээд, хураагаад явчихна. Ийм юмнаас болоод хээл хахууль жинхэнэ цэцэглэж байсан. Би УИХ-ын Ажлын хэсэг ахалж байсан тэгээд судлаад, гаргаад үзэхэд нийт 6000 тусгай зөвшөөрөл байсан. Тэрийг Тусгай зөвшөөрлийн хуулиар 108 болгож, гурван жилээс доошгүй хугацаагаар олгодог болсон. Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 52 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тэгсэн одоо тэр зөвшөөрөл дахин цэцэглэсэн юм байна. Монгол Улс хуулиар явах ёстой байтал заавраар явдаг болсон. Хуулиасаа айхтар нөхцөлтэй заавар гаргачихна. Тэр зааврыг хэн гаргаж байгаа гэхээр нөгөө хүнд сурталтнууд өөрийнхөө таашаалд нийцүүлж гаргаж байна.

## Урсгал ус хүчтэй ороод ирсэн, замыг нь хэрхэн засах вэ гэдэг л байна

### -Монгол Улсын хөгжлийг Та хэрхэн харж байна вэ?

-Улс хөгжихгүй байна гэж хэлж болохгүй. Өөрийнхөө компаниар жишээлээд үзсэн ч, эргэн тойрны өндөр барилгуудыг харсан ч тэр. Ус хүчтэй ороод ирчихсэн. Тэрний өмнө том боолт хаалт байгаа нь төрийн бодлого. Тэрийг л зөв тавиад өгвөл ус зүгээр урсчих гээд байна шүү дээ.

-Бизнесмэн хүн мөнхийн завгүй. Гэтэл эрүүл байж гэмээнэ зорьсон санасандаа хүрэх учиртай. Та

## туршлагатай бизнесмэний хувьд залуу хүмүүст эрүүл мэндээ бодох талаар юу гэж зөвлөх вэ?

-Бизнесийн орчин хэцүү, дээр нь ажиллуулж байгаа хүмүүс маань юу билээ. Харьцаж байгаа харилцагчид маань ямар билээ. Бухимдах юм их. Тэр болгонд стресстээд байж болохгүй. Өнөөдөр хийх гэсэн зүйлээ амжуулсан. Ийм зүйл хийх гээд байсныхаа ард гарлаа гэдгээсээ таашаал аваад, амрах, хооллохоо зохицуулаад байвал эрүүл байна. Дандаа бизнес бодоод байж болохгүй. Өөрийгөө боловсруулах ч гэдэг юм уу, өөр зүйлд анхаарал хандуулж байх хэрэгтэй. байна. Хүүхдүүд явуулж байгаа болохоор би ч одоо бизнесийн ачааллаас харьцангуй хөндий байна. Ном унших, бүтээл туурвих бол стресс тайлах, тархи амраах нэг арга.

### -Та сүүлийн үед өөрөө ч ном бичиж, "Номин холдинг" ч бусдын номыг их ивээн тэтгэж байна л даа.

-Судалгааны чиглэлд жаахан ажиллаж байгаа. Монголын хэл, соёл харамсалтай болж байна. Өөрөөрөө жишээ авахад л манай ач нар цэцэрлэгээсээ эхлээд гадаад хэлний сургалттай сургуульд яваад, 10 жилээ дүүргэчихэж байна. Хэлийг дагаад сэтгэлгээ өөрчлөгддөг. Тэгэхээр монголоороо яриад байгаа боловч монгол сэтгэлгээ байхгүй болж байна гэсэн үг. Би зүйр цэцэн үгийн хэд хэдэн ном гаргасан. Ач нартаа нэг зүйр цэцэн үг ойлгуулах гэж нэлээд ажил болох шинжтэй. Тэгээд ч нэг их сонирхох ч үгүй юм шиг байна. Худан монголоор надаас эхлээд бичихгүй, уншихгүй. Тод монгол гээчийг бүр мэдэхгүй. Энэ жил би Шиньжээнд баруун Монголын өв соёлыг сонирхож, судалж явлаа. Тэнд торгууд хэл бүрэн бүтнээрээ хадгалагдаж байна. Би өөрөө торгууд хүн. Өв соёл нь бас хадгалагдаж байна. Тууль хайлж, домбор, товшуураа цохиж, уртын болоод богинын дуу дуулж байна. Торгууд ардын уртын дуу 550 байна. Түүнээс би 250-ыг нь дуулдаг юмаа гэсэн уран сайханчтай ч таарсан.

### -Та их чухал юм хэллээ. Монгол сэтгэлгээ гэж. Энэ бол монголчуудын хөгжүүлж, авч явах ёстой зүйл.

-Чингис хаан сургууль төгсөөгүй, бичиг үсэг мэддэггүй байсан. Тэгэхдээ дэлхийг төвхнүүлээд явж байсан хүн. Тэрийг ямар сэтгэлгээ гэх вэ. Монгол сэтгэлгээ. Дэлхий нийтэд Чингисийн менежмент гэж ярих болсон байна. Тийм аугаа зүйлийг хэрэглэнэ гэдэг чухал. Эрдэмтдийн ярианаас үзэхэд, монгол хүний ген бусдаас дутуугүй гэдэг. Сурах авьяас, сэтгэх сэтгэлгээ өндөр байна. Монгол сэтгэлгээ байхгүй бол Монголыг хөгжүүлэх тал дээр тэр хүн ажиллаж чадах уу гэдэг асуудал. Харин монгол хэл, соёлоо нэвтэрхий сурчихаад гадаад хэл сурахад асуудалгүй. Бямбын Ренчин, Цэндийн Дамдинсүрэн монгол хэлийг төгс мэдэхийн сацуу гаднын олон хэл мэддэг байж. Ер нь тэгээд бизнест ч гэсэн хараад байхад монголоороо байгаа нь илүү амжилт гаргаад байх шиг. Их олон хэлтэй, эрдэмтэй нь эрдмийн ажил хийнэ үү гэхээс бизнест бас явахгүй байна.

-Манай уншигчдад туршлагаасаа хуваалцаж, үнэ цэнэтэй зөвлөгөө өгсөн танд баярлалаа. ■



ABOVE AND BEYOND

# THE NEXT GENERATION RANGE ROVER



## ВАГНЕР АЗИ АВТОМОТИВ

Нарны зам 55/1, Тээвэрчидийн гудамж, 14253  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс  
Утас: 99118301, 99118375, 99108303, 99108368



[www.waa.mn](http://www.waa.mn)



### Тансаг дотоод дизайн

Өмнөх загвараасаа илүү энгийн ойлгомжтой, тансаг дотоод дизайн, 8 инчийн Dual view touchscreen display-н тусламжтайгаар товчлуурын тоо 50 хувиар цөөрсөн.




### Four-Zone Climate Control

Машины 4 гол суудалд зорчих хүн бүр өөрт тохируулан орчныхоо температурыг өөрчлөх зориулалттай технологи юм.



### Terrain Response®2

2013 оны Range Rover загварын *Гадаргуу мэдрэх технологи*®2 нь автомашины хурд, өндөр, араа, амортизатор зэргийг тухайн замынхаа бартаа саад, нөхцөлд автоматаар тохируулж болдог сүүлийн үеийн дэвшилтэт систем юм.



### 8 шатлалт автомат хурдны хайрцаг

8 шатлалт автомат хурдны хайрцагтай болсноор шатахуун зарцуулалтыг 10%-иар бууруулжээ. Уламжлалт араа солих аргыг өөрчлөн эргэдэг болгосон нь энэхүү машины бас нэгэн дэвшилтэт технологи юм.



### Энтертаймент технологи

Суудлын дэрэнд суурилагдсан 2 ширхэг 8 инчийн дэлгэц, WhiteFire® брендийн утасгүй 3 чихэвч, удирдлага, USB оролт зэргээс бүрдсэн арын суудлын энтертаймент технологи нь ойрын болон алсын замд зорчигчдыг хором ч уйдаахгүй байх зориулалтаар тусгайлан бүтээгджээ.



### 8 inch Dual view touchscreen

Дэлгэцийг жолооч болон зорчигч талаас нэгэн зэрэг харахад, хоёр өөр дүрс харагдана.

900mm



### Ус туулах чадвар

Үйлдвэрлэгч компанийн зүгээс 2013 оны Range Rover загварын хөдөөний замд явах чадварт онцгой анхаарал хандуулж ус туулах чадварыг нь 90 см болгон ихэсгэжээ.

+75mm



### Өөрийгөө өндөрлөх чадвар

Шинэ технологи ашиглан бүтээсэн хийн нумын тусламжтайгаар 2013 оны Range Rover өөрийгөө 7.5 см өндөрлөх бололцоотой болжээ.

Үзүүлэлт	RANGE ROVER 2012		RANGE ROVER 2013	
	4.4L SDV8	5.0L V8 Supercharged	4.4L SDV8	5.0L V8 Supercharged
Хөдөлгүүр	4.4L SDV8	5.0L V8 Supercharged	4.4L SDV8	5.0L V8 Supercharged
Хотын замд L/100 км	18-20 литр	25-28 литр	<b>16-18 литр</b>	<b>22-25 литр</b>
Шулуун замд L/100км	12-14 литр	15-18 литр	<b>10-13 литр</b>	<b>13-16 литр</b>
Дундаж L/100км	15-17 литр	20-23 литр	<b>13-15 литр</b>	<b>18-21 литр</b>

### Шатахуун зарцуулалт\*

2013 оны Range Rover бүх бие нь хөнгөн цагаан материалаар хийгдсэн тул өмнөх загвараасаа 400 гаруй килограмм хөнгөн, шатахуун зарцуулалт 10% бага болжээ.

\*Монголын нөхцөлд өвлийн улиралд тооцсон шатахуун зарцуулалтын хэмжээ

Үзүүлэлт	RANGE ROVER 2012		RANGE ROVER 2013	
	4.4L SDV8	5.0L V8 Supercharged	4.4L SDV8	5.0L V8 Supercharged
Хөдөлгүүр	4.4L SDV8	5.0L V8 Supercharged	4.4L SDV8	5.0L V8 Supercharged
100 км/цаг Хурд авалт	7.8 секунд	6.2 секунд	<b>6.9 секунд</b>	<b>5.1 секунд</b>
Морины хүч	313	510	<b>339</b>	<b>510</b>
Арааны тоо	8	6	<b>8</b>	<b>8</b>

### Хөдөлгүүрийн хүч

2013 оны Range Rover 0-100 км/цаг хүрэх хугацаа 17%-иар буурч, улам хүчтэй хурдан болжээ.